

**04 дүгээр сарын үйл ажиллагааны мэдээ****Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар**

Сонгуулийн тухай хуулийн дагуу 2020 оны УИХ-ын ээлжит сонгуулийг зохион байгуулах Сүхбаатар аймгийн сонгуулийн хороог байгуулжээ. Сонгуулийн хороог 9 хүний бүрэлдэхүүнтэй баталсан бөгөөд байгуулагдсан Сонгуулийн хороо 2 удаа хуралдаж 13 сумын сонгуулийн салбар хороог байгуулж, хорооны дарга нарыг томилсон байна.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд орон нутгаас санал авч байгаатай холбогдуулан шинээр нэмэх 15, хасах 3, өөрчлөлт, засвар хийх 15 саналыг 2 сумын Засаг даргын Тамгын газар, төрийн захиргааны 2 ахмад ажилтан болон аймгийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдаас ирүүлсэнийг нэгтгэн дээд шатны байгууллагад хүргүүлээд байна.

Улсын Онцгой комиссын шийдвэрээр 05 дугаар сарын 31-нийг хүртэл улс орон даяар зохион байгуулагдаж буй "Маскаа зүүцгээе" аяныг аймгийн ЗДТГ-аас дэмжин ажиллаж байгаа бөгөөд аймгийн ЗДТГ-ын мэргэжилтнүүд худалдаа үйлчилгээний байгууллага, өрхийн болон нэгдсэн эмнэлэг, нийтийн гудамж талбай зэрэг олон хүн цуглардаг газруудаар явж 1500 ш амны хаалтыг иргэдэд тараалаа.

Коронавирусний халдвараас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Улсын Онцгой комиссоос гаргасан уриалгыг дэмжиж Сүхбаатар аймгийн Жавхлант бөхийн дэвжээний хамт олон аймгийн Онцгой комисст 9000 ширхэг амны хаалт хандивлалаа. Одоогоор аймгийн Онцгой комисст аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс 67,2 сая төгрөг бэлнээр, 20 орчим сая төгрөгийн бараа, эд материал хандиваар цуглаад байгаа аж.

"Засгийн газрын 2019 оны "Төрийн үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай" 149 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд Харилцаа Холбоо Мэдээлэл Технологийн газартай хамтран ажиллах гэрээ байгуулж, 13 суманд цахим шуудангийн хаяг \gov.mn\ нээлгэж, домайн нэрийг аваад байна. Түүнчлэн Үндэсний Дата Төвтэй хамтран ажиллах гэрээ байгуулж Төрийн үйлчилгээг операторын тогтолцоонд шилжүүлэх, тоон гарын үсэг нэвтрүүлэх, ажлыг эхлүүлээд байна.

**Хяналт шинжилгээ, үнэлгээний чиглэлээр:** ХШҮДАХэлтэс нь Улсын тэргүүний сум шалгаруулах болзлыг хангасан тус аймгийн Уулбаян, Хэнтий аймгийн Баян-Овоо сумын Зүүн бүсийн зөвлөлд хүргүүлсэн тайлан материалд харьцуулсан дүн шинжилгээ хийж зөвлөмж зөвлөгөө өгсөн ба ажлын хэсгийн дүгнэлтийн талаар дээд шатны байгууллагад албан хүсэлт явуулсан.

**Хоёр. Эдийн засаг, төсөв санхүүгийн хүрээнд:**

Улсын төсвөөс санхүүгийн дэмжлэгээр болон тусгай зориулалтын шилжүүлгийн орлогоор нийт 15,509.2 сая төгрөг авсан ба орон нутгийн төсөвт 2,229,2 сая төгрөгийн орлого орж нийт 17,738,4 сая төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж ажиллалаа.

Эхний 4 сарын байдлаар Улсын төсөвт 958,6 сая төгрөг төвлөрүүлэхээс 903,7 сая төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 94,3 хувиар, Орон нутгийн төсөвт 2486,0 сая төгрөг төвлөрүүлэхээс 2503,6 сая төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 100,7 хувиар тус тус биелүүлсэн байна.

Аймгийн төсвөөс сумдад 1996,4 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгож, орон нутгийн төсвийн 13 байгууллага болон тусгай зориулалтын шилжүүлгийн 56 байгууллагад нийт 14,457.3 төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн орлогын шилжүүлэг эхний 4 сарын байдлаар төлөвлөгөө 3,443,177,8 мян.төгрөг үүнээс гүйцэтгэлээр 412,220,9 мян.төгрөг шилжиж орж ирсэн.

Сумдад 4 сарын гүйцэтгэлийн дагуу итгэлцүүрээр 123,666,1 мян.төгрөг хуваариллаа. /Уул уурхайгаас орж ирэх тусгай зөвшөөрлийн төлбөр, АМНАТ-ын төлбөр улирлаар гүйцэтгэлээр орж ирнэ/ Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж буй ажлын гүйцэтгэлийн санхүүжилт 526,900,0 мянган. төгрөг. ТА-3 төслөөс 2019 оны жилийн

гүйцэтгэлийн үнэлгээний урамшуулал дэмжлэг 441,095,8 мян.төгрөгийг сумдад шилжүүлээ.

2019 оны улсын орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд төрийн аудитын байгууллага гүйцэтгэлийн аудит хийж нэгдсэн дүгнэлт зөвлөмж өгч ажилласан.

**Татварын хэлтэс:** ХХОАТ-ын тухай хуулийн заалтын дагуу татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэхээр хүсэлтээ ирүүлсэн 896 иргэдийн 464,2 сая төгрөгийн буцаан олголтын материалыг шалгаж хүлээн авч баталгаажуулан ажиллалаа.

**Орон нутгийн өмчийн газар:** Орон нутгийн өмчит 11 байгууллагаас хөрөнгө актлах, худалдах, шилжүүлэх санал хүсэлт ирүүлсэн бөгөөд тухай бүр хариуг шийдвэрлэсэн байна. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны 05 дугаар тогтоолын дагуу дуудлага худалдааг 2020 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр зохион байгуулахаар төлөвлөсөн байна.

2020 онд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр нийт 94 нэр төрлийн 23,699,2 сая төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авахаар төлөвлөгдсөн байна. Үүнд:

1. Улсын төсвөөс санхүүжилтээр 31 нэр төрлийн 11,032,3 сая төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ
2. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 55 нэр төрлийн 11,342,4 сая төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ
3. Төсөл, хөтөлбөрийн хөрөнгөөр 7 нэр төрлийн 1,324,4 сая төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ
  - Гүйцэтгэгч нь тодорч гэрээ байгуулсан 32 нэр төрлийн 4142,6 сая төгрөгийн бараа ажил, үйлчилгээ, зарласан 26 нэр төрлийн бараа, ажил, үйлчилгээ /Хүлээж авах хугацаа болоогүй/
  - Эрх шилжсэн 11 нэр төрлийн бараа, ажил, үйлчилгээ, зарлагдаагүй зураг төсөв хүлээгдэж байгаа 34 нэр төрлийн бараа, ажил, үйлчилгээний тендер байна.

Төсвийн хэмнэлт 232 сая төгрөг бөгөөд төлөвлөгөөний биелэлт 68,3 хувьтай байна.

**Санхүүгийн хяналт, аудитын алба:** Эрдэнэцагаан, Сүхбаатар сумдын төсөвт газруудын 2018,2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд нь төлөвлөгөөт санхүүгийн хяналт шалгалт, ЗДТГ, ИТХурал, Хайлааст голомт ОНӨААТҮГ, Чоно гол хөгжил ОНӨААТҮГ, Бичигт их өргөө ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаанд нь дотоод аудит, мөн Аймгийн хөрөнгө оруулалт, барилга,байгууламжийн ажлын захиалагчийн хяналтын зардалд дотоод аудит хийж акт, албан шаардлага, зөвлөмжүүдийг хүргүүлж ажиллалаа.

#### **Гурав. Хууль эрх зүйн салбарт:**

Засгийн газрын 2018 оны 50 дугаар тогтоолоор батлагдсан “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх салбар дундын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хэрэгжилтэд хяналт тавих үүрэг бүхий аймгийн зөвлөлийг байгуулахтай холбогдуулан холбогдох албан хаагчдын судалгааг 26 агентлаг, албадаас нэгтгэн авлаа.

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 “а”, 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Монгол Улсын Их Хурлын 2016 оны 51 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь заалтыг үндэслэн Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2020 оны төлөвлөгөөг боловсруулан аймгийн Засаг даргад танилцуулж, батлууллаа. Уг төлөвлөгөөг нийт агентлаг, алба, сумдын ЗДТГ-т хүргүүлж, хэрэгжилтийг ханган ажиллахыг үүрэг болгосон.

**Архивын чиглэлээр:** Лавлагаа 106, хуулбар 52 нийт 158 иргэдэд хөдөлмөрчдөд давхардсан тоогоор 7900 гаруй хадгаламжийн нэгжээр үйлчилсэн.

Цахимд хадгаламжийн нэгж буюу 1326 хуудас баримтыг сканнер, photoshop-д оруулж, 373 заалт баримтыг програмд оруулсан байна.

Нөхөн бүрдүүлэлтээр барилгын зураг төслийн 25 хадгаламжийн нэгж хүлээн авсан.

**Улсын бүртгэлийн хэлтэс:** Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн мэдээ авсан мэдүүлгийн тоо 185, анхны бүртгэл 25, өмчлөх эрх шилжих



Сүхбаатар аймгийн хэмжээнд нээлттэй даалгаврын сан үүсгэх ажил эхэлж 610 багшид даалгавар зохиох, даалгавар шивэх эрх олгов.

Боловсрол соёл урлагийн газрын зөвлөн туслах баг Онгон, Наран, Дарьганга сумдад ажиллаж теле хичээлийн хандалт, багш нарын теле хичээлийн түгээлт, сурагчидтай холбогдож буй байдал, элсэлтийн ерөнхий шалгалтын бэлтгэл ажилтай танилцаж зөвлөмж дүгнэлт өглөө.

Боловсролын хүрээлэн “Суралцагчдын ялгаатай байдлыг сургалтад харгалзах нь – үйл ажиллагаа, үр дүн” сэдэвт үндэсний эрдэм шинжилгээний хурлыг 04 дүгээр сарын 27 - ны өдөр зохион байгуулж, тус хуралд Баруун-Урт сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн Нийгэм, түүхийн ухааны багш М.Ариунзул “Сурагчдын оюуны үйлийн хэв шинжийн онцлогт тохирсон дасгал, даалгавар боловсруулах арга зүй” сэдвээр илтгэл хэлэлцүүлээ.

**Гэр бүл, хүүхэд, залуучуудын чиглэлээр:** Гамшиг онцгой байдлын үед тусламж үйлчилгээ үзүүлэх 24 Сайн дурын ажилтныг бүртгэж, нийт 10 сайн дурын ажилтныг танилцах, анхан шатны мэдлэг олгох сургалтад хамрууллаа.

Ковид-19 вирусын халдвараас урьдчилан сэргийлэх онцгой нөхцөл байдал үүсч, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаанд хорио цээр тогтоосонтой холбогдуулан, Үлгэрч аав ээж аяны хүрээнд эцэг эхчүүд хүүхдийнхээ чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд анхаарах, үлгэрээр хүүхдээ хүмүүжүүлэх Монгол ухаанд сургах, өв соёлоо дээдлэн залуу хойч үедээ өвлүүлэх, гэр бүлийн эерэг таатай орчин бүрдүүлэх зорилготой цахим видео бичлэгийн уралдааныг 2020.04.07-ны өдрөөс 2020.04.25-ны өдөр хүртэл зарлаад байна.

Залуучуудын мэдээллийн санг бүрдүүлэх статистикийн нэгдсэн үзүүлэлтийг Үндэсний статистикийн хорооны даргын 2018 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/153 тоот тушаалаар батласан “Залуучуудын статистикийн нэгдсэн үзүүлэлт түүнийг тооцох аргачлал” –ын дагуу бүрдүүлсэн.

Уур бухимдлыг хэрхэн зохицуулах, стерссийг даван туулах, Хүчирхийлэл үйлдэх зан үйлийг хэрхэн зохицуулах, Бэлгийн замаар дамжих халдвар, ХДХВ/ДОХ-ын талаар зан үйл засах сургалтыг түр саатуулахад буюу баривчлагаанд байгаа иргэдэд зохион байгуулж, Сэтгэлзүйн цуврал подкастыг санаачлан, эхний дугаарыг Стрессээ хэрхэн зохицуулж сурах вэ? сэдвээр хүргэсэн. Хандалтын тоо 1545 хүрсэн. Мөн дархлаагаа дэмжиж, хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх зорилготой бүжгийн сургалтад 20 залууг үнэ төлбөргүй бүртгэн, олон хүн цуглуулахгүй үүднээс хуваарь гарган хичээллэж байна.

Үндэснийхээ өв соёлыг хөгжүүлэх, өсвөр үе залуучуудад өвлүүлэн, түгээн дэлгэрүүлэх, сурталчлах, хүүхэд залуучуудын бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, амьдрах ухаанд суралцуулах зорилготой “Өв соёлоо үр хүүхэддээ өвлүүлье” гар урлалын бүтээлийн цахим уралдааныг 03 дугаар сарын 25-наас 05 дугаар сарын 01 хүртэл зарласан.

“Хүүхэд-эрхэм хэрэглэгч” аяны хүрээнд гэр бүлийн орчинд хүүхдийн аюулгүй байдлыг байдлыг хангах, хамгаалах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор эхлүүлсэн #Safety Check Challenge-д нэгдэж нэвтрүүлэгт оролцож иргэдийг уриалсан.

Гэр бүлийн зөрчил үйлдэж аймгийн Цагдаагийн газарт баривчлагдсан иргэдэд “Зан үйлд нөлөөлөх сайн дурын сургалт”-ын хөтөлбөрийн дагуу 24 иргэн сургалтад хамруулж, Нийгэм, сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээнд 12 иргэнд зөвлөгөө үйлчилгээ үзүүлсэн.

ГБХЗХГ-аас Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвтэй хамтран зохион байгуулсан “Сэтгэцийн эрүүл мэнд ба сэтгэл зүйн тусламж үзүүлэх анхан шатны мэдлэг олгох”, Хүүхэд, ГЭР БҮЛД НИЙГЭМ СЭТГЭЛ-ЗҮЙН АНХНЫ ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЭХ НЬ” зэрэг онлайн сургалтанд 4 хүн хамрагдаж, сумдын хамтарсан багийг мэргэжил арга зүйгээр хангаж зөвлөмж өгч, Зорилтот бүлгийн өрхийн хүүхдүүдийг витаминжуулалтад хамрууллаа

“Хайрын сар аян”-ыг өрнүүлж “Халамжлая- Хамгаалья” арга хэмжээг эхлүүлж, “Хайрын бэлэг хүүхэд” арга хэмжээг 11- р цэцэрлэгийн хөдөлгөөн засалч эмч, Тусгай хэрэгцээт шаардлагатай бүлгийн багш нартай хамтран 4 цувралт теле хичээлийг эхлүүлж, Насанд хүрээгүй хүмүүсийг зам тээврийн осолд өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх, амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах зорилгоор “Хамгаалагдсан хүүхэд - Хариуцлагатай аав, ээж” нэгдсэн арга хэмжээг 04 дүгээр сарын 10-ны өдрөөс

эхлэн 06 дугаар сарын 10-ныг хүртэл зохион байгуулахаар аймгийн Засаг даргын 2020 оны А/263 дугаар захирамжийг гарган хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

**Соёл урлагийн чиглэлээр:** Соёл, урлагийн салбарын 2019 оны үйл ажиллагааны статистик мэдээг шинэчлэгдсэн маягтын дагуу боловсруулж байна.

Соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах болон хөхиүлэн дэмжих тухай 2005 оны конвенцийн хэрэгжилтийн мэдээллийг боловсруулан ажиллаж байна.

Онгон, Наран, Дарьганга сумдын салбарын байгууллагуудын үйл ажиллагаа, улсын төсвийн хөрөнгө оруулалтын ажлын нөхцөл байдалтай Боловсрол соёл урлагийн газрын дарга, мэргэжилтнүүд газар дээр нь очиж танилцлаа.

**Хөгжимт жүжгийн театр:** Шинэ коронавируст цар тахал, хорио цээр, цаг үеийн байдлаас шалтгаалан соёл урлагийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах боломжгүй болсон учир 04 дүгээр сарын 06-ны өдрөөс эхлэн 58 ажилтан, албан хаагчдад ээлжийн амралт олгоод байна.

Ажлын чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах зорилгоор зарим ажилтнуудын албан тушаалыг өөрчилж, ажлыг нь хүлээлцүүлэн ажиллалаа.

Байгууллагын үйл ажиллагааг сурталчлах зорилгоор Сүхбаатар аймгийн нийгэм, улс төр, мэдээллийн 7 хоног тутмын хэвлэл “Сүхбаатар өнгө” сонинд “Эдип, Маш нууц жүжгийг Гэгээн музад сойж байна” нэртэй нийтлэлийг 4 дүгээр сарын 06-ны өдрийн №09/105/ дугаарт оруулж, олон нийтэд түгээсэн.

**Нийтийн номын сан:** Байгууллагын үйл ажиллагаа болон тэмдэглэлт өдрүүд, цаг үеийн байдалтай холбоотой мэдээ мэдээллийг байгууллагын цахим хаягаар тогтмол хүргэн сурталчилж байна.

Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан номын сангийн цахим үйлчилгээнд техникийн шинэчлэл хийх 19.0 сая төгрөгийн санхүүжилт бүхий ажлыг “Нэкстдистрибьюшн” ХХК гүйцэтгэж хүлээлгэн өглөө

Дэлхийн номын өдрийг угтаж Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлийн гишүүн, ган үзэгтэн шагналт, Боловсролын тэргүүний ажилтан, ахмад багш Д. Сэнгэдоржтой онлайн уулзалт, “Хүмүүн” шинэ номын нээлтийг зохион байгуулах “Миний шилдэг ширээний ном” уралдаан, Сүхбаатар аймгийн зохиолч, яруу найрагчдын цуврал танилцуулга зэргийг зохион байгуулахаар төлөвлөж, нутгийн зохиолчдын амьдрал, уран бүтээлийн танилцуулгыг цувралаар бэлтгэн цахимаар сурталчлах ажлыг хийсэн. Мөн “Миний ширээний шилдэг ном” уралдаанд оролцогчдын номын танилцуулгыг онлайнаар зохион байгуулж байна.

**Угсаатны зүйн музей:** Байгалийн танхимын үзмэрүүдээр, сургууль цэцэрлэгийн насны хүүхдүүдэд зориулсан анимэшн хийгдлээ.

1407 ш соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалтыг гаргаж, аймгийн НБХэлтэст ирүүлсэн.

Соёлын биет бус өв тээгчийг алдаршуулах зорилготой “Уудалж баршгүй өв соёл” нэвтрүүлгийг орон нутгийн BBS телевизтэй хамтран үзэгчдийн хүртээл болголоо. Уг нэвтрүүлэгт Баруун-Урт сумын 8-р багийн иргэн өвлөн уламжлагч С.Батсүх оролцлоо.

Чулуун соёлын өв хөтөлбөрийн хүрээнд Эрэнэцагаан сумын нутагт Хөндлөн хавцал гэдэг газраас олон тооны тамга дүрслэл бүхий хадны зурагт хэмжилт хийн Археологийн хүрээлэн болон Соёлын өвийн үндэсний төв рүү цахимаар мэдээлэл хүргүүлж шинээр бүртгэхээр бэлтгэж байна. Зотол хаан уулын баруун хойд талд орших Яаман хадны 3 м орчим агуйг шинээр бүртгэхээр бэлтгэж байна.

**Биеийн тамир, сортын чиглэлээр:** Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэх зорилгоор BBS телевизтэй хамтран спортын төрлүүд болон гэрийн нөхцөлд идвэхтэй хөдөлгөөн, бие бялдарын чадвар, чадамжийг дээшлүүлэх зорилгоор цуврал болгон TV хичээл бэлтгэн явуулж байгаа бөгөөд 2020 оны 04 дүгээр сарын 11-ний өдрөөс эхлэн Волейболын спорт, Самбо бөхийн спортын танин мэдэхүйн хичээлүүдийг бэлтгэж гарган ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын А/288 дугаар захирамжийн дагуу Усан спорт, чийрэгжүүлэлтийн төв, Ханан фитнес клубын үйл ажиллагааг мэргэжлийн байгууллагаас тавьсан шаардлагыг хангуулж, 2020 оны 04 сарын 23-ны өдрөөс эхлэн тусгай горимоор ажиллуулж байна.

**Эрүүл мэндийн чиглэлээр:** Эрүүл мэндийн байгууллагад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэн явуулах тусгай зөвшөөрөл олгох хурлыг 2 удаа зохион байгуулж 3 байгууллагын тусгай зөвшөөрлийн хугацааг сунгалаа.

Магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагад явцын үнэлгээ хийх журмын дагуу АНЭ-т явцын үнэлгээ хийж 19 заалт бүхий зөвлөмж хүргүүлэв.

Ковид-19 халдварын үеийн бэлэн байдлыг хангах чиглэлээр эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд зориулсан видео хичээлийг бэлтгэн байгууллагын Youtube суваг болон вэб сайтад байршуулав.

Бичигт боомтод ажиллаж буй эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг Ковид-19 халдварын үед ажиллах журам, халдварын сэргийлэлт, хяналт, ариутгал, халдваргүйтгэл, эмнэлзүйн удирдамж, оношилгоо эмчилгээ зэрэг сэдвүүдээр 2 өдрийн сургалтад хамруулж шаардагдах эмнэлгийн хэрэгсэл, багаж материалаар хангалаа.

Ковид-19 халдварын үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээ зохион байгуулах талаарх цахим сургалтыг долоо хоног бүрийн пүрэв гарагт сум дундын эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг хамруулан зохион байгуулж байна.

Сувилахуйн сургуулийн окутан болон сайн дурын идэвхтэн нарт COVID-19 халдварын үед Халдвар хамгааллын хувцас өмсөх тайлах дараалал, гарын эрүүл ахуйн талаар сургалт зохион байгуулсан. Нийт 15 хүн хамрагдсан.

Цагдаагийн байгууллагын 53 албан хаагч нарт COVID-19 халдварын тухай, Халдвар хамгааллын хувцас өмсөх тайлах дараалал, гарын эрүүл ахуйн талаар сургалт зохион байгуулсан.

Коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, халдварын үед ажиллах эмч эмнэлгийн мэргэжилтний бэлтгэл бэлэн байдлыг хангах, халдвар хамгааллын хувцсыг өмсөх тайлах дарааллыг дадлага сургалт, яаралтай болон амилуулах суурь тусламж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чиглэлээр эрүүл мэндийн байгууллагууд дотоодын дадлага сургалтад давхардсан тоогоор 496 эмч эмнэлгийн ажилтныг хамруулан ажилласан байна.

Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх, маскаа зүүцгээе аяны хүрээнд амны хаалтаа тогтмол зүүж хэрэглэх, хэвшүүлэх чиглэлээр 831 байгууллагад санамж байршуулан, 1822 өрх, 12955 иргэн, 7388 эмнэлгийн байгууллагаар үйлчлүүлсэн иргэдэд мэдээлэл, сурталчилгааг зохион байгуулан ажилласан байна.

Олон нийтийн цахим сүлжээ(Facebook)-гээр корона вирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, санамж сэрэмжлүүлэг зэрэг 1261 төрлийн мэдээлэл байршуулж 7745 хандалт авч ажилласан байна. Орон нутгийн телевизээр 4 төрлийн шторкийг өдөрт 7-8 удаа нийт 200 гаруй удаагийн давтамжтай нэвтрүүлсэн байна.

Хачигт энцефалитын эсрэг вакцинжуулалтанд Онцгой байдлын газрын 105 албан хаагчдын 97/92,3 % нь хамрагдаж, бүрэн тунгийн хамралт 90%-тай байна. 2021 онд шаардагдах заавал хийх үндэсний товлолын вакцин, дагалдах хэрэгсэл, тархвар судлал, сайн дурын үндсэн дээр хийгдэх вакцин биобэлдмэлийн захиалгыг ХӨСҮТ-ийн дархлаажуулалтын албанд хүргүүлсэн. Мөн 2021 онд Зоонозын өвчний тархвар судлалын заалтаар хийгдэх вакцин биобэлдмэлийн захиалгыг ЗӨСҮТ-д хүргүүлээ.

**Хөдөлмөр эрхлэлтийн талаар:** 04-р сарын байдлаар хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй ажил хайгч 798 иргэнээс эмэгтэй 372 бүртгэлтэй ажилгүй иргэн 594 иргэнээс, эмэгтэй 273 иргэн байна. Тайлант хугацаанд 315 ажлын байрны захиалга бүртгэгдэж, 186 иргэнийг ажилд зуучилсан байна. Ажилд зуучлагдсан иргэдийн 99 иргэн буюу 53,2 % нь байнгын ажлын байртай болсон байна. Шинээр бий болсон 88 ажлын байрны мэдээллийг хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн.

COVID 19 вирусээс сэргийлэх зорилгоор ажил хайгчаар бүртгүүлэх, сэргээх болон ажилгүйдлийн тэтгэмжийн тодорхойлолтыг цахимаар болон утсаар бүртгэн ХЗЗ-н мэдээллийн нэгдсэн санд 25 ажил хайгч, 11 иргэний ажилгүйдлийн тэтгэмжийн тодорхойлолтыг нийгмийн даатгалын хэлтэст гаргаж өгөв.

ХАБЭА-н сарын аян зохион байгуулах аймгийн Засаг даргын 2020 оны 3 сарын 27-ны А/237 дугаар захирамж гарч ажлын хэсэг томилогдон ажиллаж байна.

Зохион байгуулах ажлын хэсэг 1 удаа хуралдан хийх ажлын төлөвлөгөө гарган зөвлөлийн даргаар батлуулан цахим орчинд мэдээллийн хэрэгслээр дамжуулан иргэдэд мэдээлэл хүргэж байна. Аяны баннер, шторк, ХАБЭА-н ажилтнуудад зориулсан гарын



авлага зэргийг бэлтгэн 1000 ширхэгийг А3, А4, А5 хэмжээтэй хэвлүүлж аймгийн төвийн албан байгууллагууд болон сумдад хүргүүлээд байна.

Ажлын байрны дарамт , хүчирхийлэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр онлайнаар санал асуулгыг явууллаа. Тус санал асуулгад 24 байгууллагын 380 хүн саналаа өгөөд байна. Саналыг нэгтгэн салбар тус бүрээр нь гарган холбогдох байгууллагуудад хүргүүлэх болно.

2019 онд ХАБЭА-г эрхэмлэгч байгууллагаар шалгарсан Цайртминерал ХХК болон Дорнод бүсийн эрчим хүчний сүлжээ Сүхбаатар салбарын ХАБЭА-н үйл ажиллагааны талаар SB телевизтэй хамтран нэвтрүүлэг бэлтгэн гаргаж байна.

Хөтөлбөрүүдийн санхүүгийн дэмжлэгийн төслүүдийг ажлын хэсгийн гишүүдэд танилцуулан саналыг нь авч байна. Одоогоор ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн санхүүгийн дэмжлэгт 39 иргэнд 195,0 сая төгрөг олгохоор батлагдаж ирсэнээс 59 төсөл ирээд байна. Ахмадын төсөлд 8 төсөлд 24,0 сая төгрөг олгохоос 26 төсөл, ХБИ-ний төсөлд 11 иргэнд 55,0 сая төгрөг олгохоос 37 төсөл ирсэнийг ажлын хэсгээрээ хэлэлцэж шаардлагатай төслүүдийг газар дээр нь очиж үзэж байна.

Дэлхийн банкнаас хэрэгжиж байгаа “ Хөдөлмөрийн зах зээлийн туршилтын хөтөлбөр”-ийн бичил бизнес эрхлэгчдийг дэмжих жижиг зээлийн арга хэмжээний сарын мэдээг гарган хүргүүлсэн. Уг арга хэмжээнд бүртгүүлсэн 26 иргэнд Зээлийн өмнөх 2 өдрийн сургалтыг ганцаарчилсан болон цахимаар зохион байгууллаа. Сургалтад хамрагдсан 17 иргэн зээлийн төсөл ирүүлснийг ажлын хэсэг хуралдан үнэлж шаардлага хангасан 17 төслийг Төрийн банкинд хүргүүлсэн.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн эргэн төлөлт 47 иргэний 12,082.2 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтийн авлагыг программд оруулах ажлыг хийж гүйцэтгэсэн.

**Нийгмийн халамжийн талаар:** 04 дүгээр сарын байдлаар нийгмийн халамжийн тэтгэвэрт 809000,0 мян.төг, тэтгэмжинд 343000.0 мян.төг, амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж 176384.0 мян.төг, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлтөнд 62000,0 мян.төг, ахмад настанд үзүүлэх хөнгөлөлтөнд 115000,0 мян.төг, хүнс тэжээлийн хөтөлбөрт 305744, мян.төг, алдарт эхийн одон 680200,0 мян.төг, алдар цолтой ахмадын хөнгөлөлтөнд 9500,0 мян.төг, насны хишиг 203740,0 мян.төг, цалинтай эхийн тэтгэмж 160166,0 мян.төг, өрх толгойлсон эцэг/эхийн тэтгэмж 50400,0 мян.төг, ихэр хүүхдийн тэтгэмж 18000,0 мян.төг, орон нутгаас 49200,0 мян.төгрөгийн санхүүжилтийг авч арилжааны банкаар дамжуулан иргэдэд олгоод байна.

13 сумын 77 иргэний нийгмийн халамжийн тэтгэмж, 6 иргэний тэтгэвэр, 6 иргэний ахмадын хөнгөлөлт, 11 иргэний хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт, 0-3 насны хүүхдээ асарч байгаа эхийн 35 хувийн хэрэг, 31 иргэний жирэмсэн эхийн хувийн хэрэг хүлээн авч хянан баталгаажуулж нийгмийн халамж үйлчилгээний мэдээллийн систем / WAIS / программд баталгаажуулсан. Сумдын мэргэжилтнүүдээс тэтгэвэр тэтгэмж хөнгөлөлт тусламж авах 106 иргэдийн жагсаалтыг авч WAIS программд баталгаажуулалтыг хийсэн.

Тусгай хэрэгслийн захиалга гар таяг 11 , даавуун бүс 12, ширэн бүс 10, тэргэнцэр 8, суултуур 11, өвдгөвч 15, алхуулагч 1 ширхэгийг гэрээт компанид захиалан иргэдэд нь хүлээлгэн өгсөн.

Ахмад настан үзүүлэх үйлчилгээнд 57 иргэний 6200,0 мян.төг, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт 8 иргэний 800,0 мян.төг, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамрагдсан 10 иргэний 5000,0 мян.төгрөгийн баталгаажуулалтыг хийж, санхүүгийн программд хөрвүүлэв. 04 дүгээр сард дутагдаж байсан 25000,0 мян. төгрөгийн санхүүжилтийг нэмэлтээр захиалан иргэдэд олгосон.

Нийгмийн халамжийн мэдээллийн санд 15 удаа хаалт татаж, тулгалт хийгээд байна. Сарын мэдээг бэлтгэхэд буцаасан орлогын мэдээлэл татагдахгүй, ихэр хүүхдийн тэтгэжийн зардал буруу, шилжүүлгийн олголт жагсаалтаас мөр сонгох боломжгүй, хаалтын гүйлгээ орж ирэхгүй, хаалт татагдахгүй зэрэг алдаа гарсныг залруулав.

Аймгийн засаг даргын 2020 оны А/18 дугаар захирамжаар хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд хамрагдсан өрхөд 10 нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүнээр үйлчилгээ үзүүлэх хүнсний дэлгүүр сонгон шалгаруулах Мөнххаан, Баруун-Урт сумын тендерийг Орон нутгийн өмчийн газраар 4 дүгээр сарын 07,22-ны өдөр тус тус зохион байгуулсан. Тендер сонгон шалгаруулах ажлын хэсэгт томилогдон ажиллаж Мөнххаан

сумын тендер хүчингүй болж, Баруун-Урт сумын Өсөхдэлгэр ундрах ХХК /Багц А/, Батгарьд Эрдэсбаяр БГБХН /Багц В/-д шалгарч албан бичгээр мэдэгдлийг хүргүүлж, хамтран ажиллах гэрээ байгуулахаар

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс нь 04 сард 2 удаа хуралдаж 12 хүүхэд орж 8 - хүүхэд асаргаа сунгагдаж, 2 - хүүхэд асаргаа шинээр тогтоосон, 2 хүүхдийн асаргааг цуцласан байна.

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоол, Аймгийн Засаг даргын захирамжаар батласан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын комисс”-н бүрэлдэхүүнд ажиллаж “Даймонд” хотхоны 1-р ээлжийн барилгад хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй орчин бүрдсэн эсэхэд үнэлгээ хийж ажиллалаа.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дэргэдэх ахмадын амралт сувилал 2020 оны 04-р сарын 15-ны өдрөөс эхлэн 17 ахмадыг амруулсан. Амралт сувилалд бариа засал, бумба, шарлага, хаш чулуун ор, хөлийн массажны цэгэн аппарат, нурууны массажны, давсан зам зэрэг сэргээн засах эмчилгээнүүдийг явуулсан. Коронавирусээс сэргийлэх чиглэлээр ахмад настнуудад өдөр бүр зөвлөгөө өгч, маскыг тогтмол зүүж буй эсэхэд хяналт тавьж, өдөрт 2 удаа ахмад настнуудын биеийн халууныг үзэж, олон нийтийн хамарсан танилцах болон хаалтын үдэшлэг, караоке зэргийг зохион байгуулаагүй болно.

Монгол Улсын Засгийн Газрын 96 дугаар тогтоолоор Нийгмийн халамжийн тухай хуулийн 13.1.5-д заасан хүүхдийн мөнгөн тэтгэмжийг өрхийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэгдсэн өрхийн 0-18 хүртэлх насны, хүүхдийн мөнгөн тэтгэмж авах хүсэлт гаргасан хүүхэд бүрд сар бүр бэлэн мөнгөөр олгоор болсонтой холбоотой Сүхбаатар аймгийн хэмжээнд огт судалгаанд хамрагдаагүй өрхийн мэдээллийн нэгдсэн санд бүртгүүлэхээр хүсэлт гаргасан өрх 14, шинээр төрсөн хүүхэд 123 бүртгэгдсэн.

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний бүлгийн төсөлд Баруун-Урт сумын 11 бүлгийн 22 иргэний төслийг хүлээн авч төсөл сонгон шалгаруулах ажлын хэсэг хэлэлцсэн. Төсөл өгсөн бүх өрхийн босго оноог гаргаж, хөдөлмөр болон халамжийн төсөлд хамрагдаж байсан эсэхийг шалгуулахад 2 бүлгийн ахлагч хөдөлмөрийн хэлтсээс буцалтгүй 1000,000 төгрөгийн дэмжлэг авсан байна. Баруун – Урт сумын 11 бүлгийн 22 иргэнээс хөгжлийн бэрхшээлтэй 2 иргэн, ахмад 7, өрх толгойлсон эцэг эх 3, зорилтот 10 өрх, иргэн төсөл ирүүлсэн. Төсөл сонгон шалгаруулах ажлын хэсэг хэлэлцээд шаардлага хангасан 5 бүлгийн 10 иргэний төслийг дэмжээд байна.

#### **Тав. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хүрээнд:**

**Барилга, хот байгуулалт, газрын харилцаа:** Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар баригдсан Дарьганга зочид буудлын барилгад аймгийн Засаг даргын А/292 дугаар захирамжийн дагуу 21 хүний бүрэлдэхүүнтэй, Баруун-Урт сумын 6-р баг Даймонд хотхоны 1 дүгээр ээлжийн орон сууцны барилгад аймгийн Засаг даргын А/238 дугаар захирамжийн дагуу Улсын комиссын ажлыг зохион байгуулж ажиллалаа.

Барилгын хөгжлийн төвөөс эрхлэн гаргадаг “Барилгын мэдээлэл” сэтгүүлд аймгийн барилгын материал үйлдвэрлэгчдийн мэдээллийг хүргүүлээд байна.

Улсын болон хувийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй барилга байгууламжид ажлыг эхлүүлэх 4 , үргэлжлүүлэх 8 зөвшөөрөл тус тус олголоо.

Барилгын материал үйлдвэрлэгч аж ахуй нэгжид үйл ажиллагааг эхлүүлэхдээ Барилгын үйлдвэрлэлийн хөдөлмөр хамгаалал, тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны хэрэгжилтийг хангах , аюулгүй ажиллагааны дүрэм, ерөнхий шаардлагыг биелүүлж ажиллахыг зөвлөлөө.

Барилгын материалын сорилт шинжилгээний лабораторид тоосго-1, хайрга-3, элс-2, үл эвдэх-10цэг дээжийг хүлээн авч нийт 16 дээжид сорилт шинжилгээ хийж үр дүнг боловсруулан хариуг олголоо.

Төрийн аудитын газраас 2019-2020 онд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл арга хэмжээний гүйцэтгэлд шалгалт хийлээ.

Газрын кадастрын мэдээллийн сангийн веб хувилбарт иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас гаргасан нийт 37 өргөдөл бүртгэгдсэн. Үүнд Худалдах, худалдан авах гэрээний үндсэн дээр газар өмчилж авах 11 өргөдөл, шинээр газар эзэмших 8 өргөдөл, Газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх 7 өргөдөл, Газар эзэмших эрхийн



гэрчилгээгээ барьцаалах 7 өргөдөл, Гэр бүлийн хэрэгцээнд нэг удаа газар өмчилж авах 1, Газар эзэмшил/ашиглалтын газрын зориулалт өөрчлүүлэх 1, Газрын өмчлөх эрхийг гэр бүлийн нэг гишүүнд шилжүүлэх 1, Өмчлөх эрхийн талбай хэмжээнд өөрчлөлт оруулах 1, өргөдөл тус тус хүлээн авч бүртгэгдсэн. Эдгээр өргөдлүүдийг хуулийн хугацаанд бүрэн шийдвэрлэсэн.

Аймгийн Засаг даргын 6 удаагийн захирамжаар 6 өргөдөл шийдвэрлэгдсэнийг газрын кадастрын мэдээллийн санд захирамжийг бүртгэсэн. Дундын сангаар дамжуулан 15 нэгж талбарт Э дугаар захиалан хүлээн авсан. Газар эзэмших эрхийн гэрчилгээг 15 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар эзэмших эрхийн гэрчилгээ олгож, гэрээ байгуулсан.

Газрын кадастрын мэдээллийн сангаас 52 иргэн аж ахуй нэгж, байгууллагад кадастрын үнэт цаасан дээр 156ш хувь баталгаажсан кадастрын зураглалаар үйлчилсэн байна.

Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системийн талаар орон нутгийн BBS телевизээр мэдээлэл өгсөн.

Газрын кадастрын мэдээллийн сан болон хаягийн мэдээллийн сангийн хаягийн тулгалтыг 1, 7 багт хийж гүйцэтгэсэн.

Аймгийн засаг даргын 2020 оны а/283 тоот захирамжаар Баруун-Урт сумын нутаг дэвсгэрт 4-н байршилд газар эзэмших эрхийн дуудлага худалдаа явуулах тухай захирамж гаргуулсан. Газар эзэмших эрхийн дуудлага худалдааг газрын биржийн цахим систем /mle.mn/ программ хангамжаар цахим хэлбэрээр явуулах бөгөөд зарыг орон нутгийн 2 телевиз, бүх сумдын фэсебүүк хуудаст байршуулсан.

ГЗБГЗЗГ-ын даргын 2020 оны а/73 тоот тушаал, Аймгийн засаг дарын 2020 оны 04 сарын 24 өдрийн А/290 тоот захирамжаар ажлын хэсэг байгуулан хаягийн мэдээлэл шалгах засварлах, зэрэгцүүлсэн хаягийн жагсаалт гаргах, хаягийн мэдээлэл үүсгэх ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулж ажиллаж байна. Үүнтэй холбогдуулан сумдад мөн ажлын хэсэг гарган хаягийн засвар өөрчлөлтийн ажлуудыг гүйцэтгэж байна.

**Мал аж ахуйн чиглэлээр:** ХХААХҮЯ-наас аймгуудын Мал үржлийн албаны дарга, мэргэжилтнүүдийг оролцуулсан “Үржлийн малд үзлэг, ангилалт хийх, цөм сүрэг бүрдүүлэх” технологит ажил, сумдын ХАА-н тасгийн мэргэжилтнүүдтэй ноолуур бэлтгэл, хаваржилт, цаг үеийн асуудлаар онлайн хурлыг тус тус зохион байгуулсан.

04 дүгээр сарын 21-нээс эхлэн Эрдэнэцагаан, Онгон, Баяндэлгэр сумдад ноолуур худалдан авах ажил эхлээд явагдсан ба Эрдэнэцагаан сум 46, Баяндэлгэр сум 60 тн ноолуур худалдан борлуулсан байна.

Зах зээл ба бэлчээрийн удирдлага төслийн хүрээнд хийгдэх бог малын угаалгын ванн, гүн өрмийн худаг, өвс тэжээлийн агуулах шинээр барих, засварлах, бренд дэлгүүр зэрэг хөрөнгө оруулалтын ажлуудын тендерүүдийг зарлаад байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх үлийн цагаан оготнотой тэмцэх ажлын Аймгийн Засаг даргын А/260, А261 дүгээр захирамжийн дагуу 5 дугаар сард энгийн механик биологийн аргаар Эрдэнэцагаан, Уулбаян, Түвшинширээ, Асгат, Наран, Онгон, Сүхбаатар, Баяндэлгэр, Халзан сумдад 70 мян/га талбайд, Мөнххаан, Түмэнцогт, Дарьганга, Баруун-Уртад сумдад микробиологийн аргаар 30 мян/га-д тэмцэх ажил хийгдэх ба энэ асуудлаар сумдын Тамгын газартай гэрээ байгуулаад байна.

Малын чанар сайжруулах хөтөлбөрийн хүрээнд цөм сүрэг бүхий ААН, өрхөөс хээлтүүлэгч, хээлтэгч үржлийн мал бойжуулж борлуулах боломжтой байгаа тул захиалга авах, хамтран ажиллах тухай албан бичгийг аймгуудын ХХААГ-т хүргүүлсэн.

Орон нутгийн хэмжээнд газар тариалангийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй ААН, иргэний, байгууллагын нэгтгэсэн судалгааг хийж гүйцэтгээд байна. Судалгаанд Төмс, хүнсний ногоо тариалагч 157 иргэн, 24 байгууллага, 3 хоршоо судалгаанд хамрагдаад байна.

Хөдөө аж ахуйг дэмжих сангаас нийлэг хальсан хүлэмжний захиалга авах тухай мэдэгдсэний дагуу Баруун-Урт, Мөнххаан, Түвшинширээ, Эрдэнэцагаан сумдын тариаланчид 13 хүлэмжийн захиалага ирүүлсэн. Захиалга ирүүлсэн иргэдийн хүсэлтийг ХХААХҮЯаманд уламжлаад байна.

Хаврын тариалалтын бэлтгэл хангах хүрээнд техник, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний ажил хийгдэж дуусан бөгөөд техник дундын үйлчилгээний ажлыг иргэдэд үзүүлж эхлээд байна.

ХААДСангаас хөнгөлөлттэй нөхцөлөөр олгож эхэлсэн улаанбуудайн үрийг орон нутгийн ААН авах хүсэлтээ хүргүүлсэн боловч хүсэлт хүргүүлсэн ААН нэгжүүдэд үрийн дэмжлэг олгогдоогүй байна. Иймд хаврын тариалалтанд Улаанбуудай үрийн дутагдал үүсээд байна.

Хөдөө аж ахуйг дэмжих санд 2012, 2015 онд хөнгөлөлттэй нөхцөлөөр олгосон бага оврын тракторын ашиглалтын судалгааг хүргүүлээд байна.

1722759 толгой мал төллөхөөс 754964 толгой эх мал буюу нийт хээлтэгчийн 43.8 төллөж гарсан төл 98.9% нь бойжиж байна. Ингэ-523, гүү-17052, үнээ-26043, эм хонь-457253, эм ямаа 254093 төллөж ботго 517, унага-16758, тугал-25742, хурга-453956, ишиг-251423 бойжиж байна. Хамгийн их нь Мөнххаан суманд 156495 толгой мал төллөсөн бол хамгийн бага нь Түмэнцогт суманд 9435 эх мал төллөөд байна.

3817010 толгой мал хаваржихаас 18014 толгой том мал хорогдсон. Үүнд: тэмээ-9, адуу-791, үхэр-1753, хонь 7422, ямаа-8039 хорогдсон. Хамгийн их хорогдол Мөнххаан /3375/, Түмэнцогт /3163/ сумдад байгаа бол хамгийн бага Эрдэнэцагаан суманд 59, Онгон суманд хорогдол гараагүй байна.

**Мал эмнэлгийн газар:** Монгол Улсын Ерөнхий Сайдын 2020 оны 01 дүгээр албан даалгавар, МЭЕГ-ын даргын 01 албан даалгавар, аймгийн Засаг даргын А/190 дүгээр захирамжийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан энэ оны 02 дугаар сарын 14-ны өдрөөс эхлэн өдөр тутам Дарьганга өртөө ХХК, Хараацайн жигүүр ХХК-ний Улаанбаатар - Баруун-Урт - Эрдэнэцагаан сумдын хүн тээврийн ирэх, буцах чиглэлийн автобусанд ариутгал халдваргүйтгэл хийж байна. Энэ сард 3 удаа, давхардсан тоогоор 32 удаа 192 мянган м/кв талбайд халдваргүйтгэлийг хийгээд байна.

Засгийн газрын 2019 оны 225 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор 2020 онд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээ зохион байгуулах талаар аймгийн Засаг дарга, Мал эмнэлгийн газрын дарга, Биокомбинат УТҮГ-ын дарга нар гэрээ байгуулан ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын 2020 оны А/208 дугаар захирамжийн дагуу шөвөг яр өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцин 108,8 мянган тунг, цусан халдварт өвчнөөс сэргийлэх 840.0 л, ДХХ энтеробактериозын хам вакцин 840,0 л, галзуугаас сэргийлэх вакцин 25,0 мянган тунг татан авч Мал эмнэлгийн газрын даргын 2020 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн А/06 дугаар тушаалын хавсралтад заасан хуваарийн дагуу сумдын МЭҮН-дэд хуваарилан олгосон ба өнөөдрийн байдлаар шөвөг яр өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 67,8 мянган бог мал хамрагдаад байна.

2020 он гарсаар орон нутагт галзуу, ДХХ, цусан халдварт, E.coli, нийлүүлгийн өвчин, нохойн гударга зэрэг өвчнүүдийн шинжилгээг арга зүйн дагуу хийж гүйцэтгэн баталгаат шинжилгээний хариуг сумын мал эмнэлгийн тасагт хүргүүлэн зөвлөмж өгч урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллаж байна.

Ундрах супермаркет, Жанжинтулга зэрэг 2 захын цагаан идээний 5 дээжинд хольц болон исгэлэнг тодорхойлох, Баруун- Урт сумын 5-р багийн иргэн Н.Батнасангийн 10 үнээний сүүнд бруцеллэзийн шинжилгээ, Жанжин тулга, Зүүн бүсийн мал, амьтны гаралтай бүтээгдэхүүн худалдан борлуулдаг захын хонины мах- 611 кг, үхрийн мах – 392кг, адууны мах–520кг зэрэг мах махан бүтээгдэхүүнийг үзлэг, шинжилгээнд хамруулан баталгаажуулан хяналт тавьж ажилласан.

Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2020 оны А/74 дүгээр тушаал, УМЭАЦТөв лабораторийн захирлын А/16 тушаалын хэрэгжилтийг хангах зорилгоор гоц халдварт шүлхий өвчний байгалийн халдварыг тандан илрүүлэх шинжилгээнд Баяндэлгэр, Түвшинширээ, Мөнххаан, Түмэнцогт сумдын нийт 8 багийн 32 өрхөөс 480 дээж цуглуулан тандалт шинжилгээ хийж гүйцэтгэлээ.

2020.04.01-өдрөөс Мал эмнэлгийн газрын эмч мэргэжилтнүүд Түмэнцогт, Уулбаян, Асгат, Түвшинширээ, Баруун-Урт сумын малчин мал бүхий иргэдийн дуудлагын дагуу нийт 5 удаагийн дуудлаганд ажиллаж малчдад малын эрүүл мэндийн тухай хууль, малчны эрх үүргийг сурталчилж ажиллаа.

2020 оны 04 дүгээр сарын 17-ны өдрөөс 04 дүгээр сарын 23-ны хооронд мал эмнэлгийн цахим системээр 167 бичилт хийгдсэнээс шалгасан 30, саатуулсан 2 /хориглосон газарлуу амьд мал оруулах гэсэн, зураг болон эзэн нь тодорхойгүй/ татгалзсан 4 /баруун 7 аймгийн эрүүл бүс рүү амьд малын шилжилт хийгдэхгүй байгаа/,

баталгаажуулалт хийлгээгүй 0, / баталсан 131 /байцаагч болон цагдаагийн хяналтаар зөвшөөрөдсөн бичиг/ байна.

Мал эмнэлгийн газрын даргын 2020.02.14-ний өдрийн хяналт тавих тухай А/03 дугаар тушаалын дагуу Баруун-Урт сумын нутаг дэвсгэрт мал, малын гаралтай бүтээгдэхүүн худалдан борлуулж буй худалдааны цэгүүдэд мал эмнэлгийн хяналт тавьж, цахим нэгдсэн системийн гэрчилгээний хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

**Хүнс, худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр:** Засгийн газрын 2020 оны 113 дугаар тогтоолоор батлагдсан “Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт, тавих журам”-ыг шинэчлэн баталсны дагуу хөнгөлөлттэй зээл олгох, төсөл сонгон шалгаруулах ажлыг 2020 оны 4 дүгээр сарын 20 өдрийн 8:30 цагаас орон даяар нэгэн зэрэг эхлүүлсэн. Үүнтэй холбоотойгоор төсөл хүлээн авах зар мэдээллийг орон нутгийн телевиз, сонин, аймгийн Засаг даргын Тамгын газар, Хүнс, хөдөө аж ахуйн газрын цахим хуудсаар олон нийтэд нээлттэй зарлаж, сумдын Засаг нарт журмын дагуу шаардлага хангасан бизнес төслийг хамруулахыг чиглэл болгож ажилласан.

Дэлхий нийтээр тархаж буй короновирус “Covid-19” халдварын нөхцөл байдлын улмаас Монгол улс бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбоотой орон нутгийн бизнес эрхлэгчдэд тулгамдаж буй хүндрэлтэй нөхцөл байдлын хүрээнд аймгийн удирдлагууд, холбогдох төрийн байгууллагууд, банк санхүү, бизнес эрхлэгчдийн төлөөлөл болох 40 гаруй хүнийг хамруулж хэлэлцүүлэг зохион байгууллаа. Хэлэлцүүлгээс гарсан санал санаачлагыг хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Засаг дарга холбогдох газруудад үүрэг болголоо.

Архи согтууруулах ундаа худалдах эрх бүхий 11 аж ахуй нэгжийн согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрлийг аймгийн Засаг даргын 2020 оны А/277, А/269 дүгээр захирамжуудаар тус тус 2 жилийн хугацаатай сунгасан байна.

Мөн тусгай зөвшөөрлийн хугацаа хэтэрсэн боловч үйл ажиллагаа явуулж байгаа болон тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгжид тавигдах ерөнхий нөхцөлийг хангахгүй байгаа аж ахуй нэгжид хяналт тавьж холбогдох арга хэмжээг авч ажиллахыг сумдын Засаг дарга, аймгийн Цагдаагийн газарт чиглэл хүргүүлж ажилласан.

Монгол Улсын Засгийн газрын санаачилгаар Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр “Зүүн бүсийн эдийн засгийн хүртээмжтэй өсөлтийг хангахад хувийн хэвшлийн оролцоог дэмжих нь” ТТ-9751 мон төслийн хүрээнд аймгийн тэргүүлэх бизнесийг тодорхойлох зорилго бүхий өрсөлдөх чадварын судалгаа, бэлэн байдлын судалгааг төслийн багтай хамтран хэрэгжүүлж нийт 320 өрх, 377 аж ахуй нэгжийн судалгааны ажлыг 100 хувь хийж гүйцэтгэн мэдээллийн баазыг үндэсний статистикийн газарлуу илгээгээд байна.

“Сүхбаатар хөгжил” ҮТПаркын үйл ажиллагаатай танилцаж, цаашид хэрхэн ажиллах талаар санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн дүгнэлтийг аймгийн Засаг даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, аймгийн удирдлагаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу холбогдох байгууллага, хэлтсүүд ажил, арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна.

**Уул уурхайн чиглэлээр:** Аймгийн Засаг даргын баталсан ажлын удирдамжийн дагуу аймгийн Засаг даргын зөвлөхөөр ахлуулсан холбогдох мэргэжлийн байгууллагын төлөөлөл багтсан ажлын хэсэг Эрдэнэцагаан сумын нутагт хууль бусаар ашигт малтмал олборлох үйл ажиллагааг таслан зогсоож, тус газрын харуул хамгаалалтын арга хэмжээг хариуцан аймаг, сумдаас томилогдон ажиллаж байгаа албан хаагчдын нөхцөл байдалтай газар дээр танилцаж, холбогдох зөвлөмж чиглэлийг өгч, цаашид харуул, хамгаалалт, ажилчдын байр, орчин нөхцлийг сайжруулах талаар санал дүгнэлт гарган ажилласан.

Бичигтийн боомтоор уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэлт гүйцэтгэхээр хүсэлт ирүүлсэн “Харгуйн тал транс”, “Максгүүр” ХХК-уудтай тээвэрлэлтийн гэрээ байгуулан холбогдох зөвлөмж чиглэлийг өгсөн.

Монгол улсын Засгийн газрын болон аймаг, сумдын Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2020 оны үндсэн чиглэлд тусгагдсан улс, орон нутгийн төсөв болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх барилга, авто замын байгууламж, бүтээн байгуулалтын ажлуудад шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах эрх олгох ажлыг зохион байгуулах чиглэл өгөх тухай аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлын 13 дугаар

тогтоолыг бүх сумд, мэргэжлийн байгууллагуудад хүргүүлэн холбогдох зөвлөмж чиглэлийг өгч ажиллаж байна.

**Зам тээврийн чиглэлээр:** Баруун-Урт сумын 1-р баг “Грийн таун” хорооллын баруун талаар урагшаа музейн урд талын 2-р тойргийн авто зам хүртэлх зам, замын байгууламжийн зураг төсөл, төсөвт өртөг боловсруулах зөвлөх үйлчилгээг “Классик роуд” ХХК-аар гүйцэтгүүлэх гэрээ байгуулсан.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр баригдах Баруун-Урт сумын 3-р баг Хөл бөмбөгийн талбайн гаднах зам талбай, авто зогсоол барих ажил, улсын төсвийн хөрөнгөөр баригдах аймгийн төвийн 7 уулзварт гэрлэн дохио, камер суурилуулах ажлын техникийн тодорхойлолтыг батлуулан Орон нутгийн өмчийн газарт хүргүүлсэн.

Улсын төсвийн хөрөнгөөр “Баруун-Урт сумын 5.5 км цэвэр ус, 2.0 км ариутгах татуургын шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэл /Сүхбаатар, Баруун-Урт/-ийн ажил”-ыг гүйцэтгэхтэй холбогдуулан Альянс-Тех ХХКомпанид авто зам, замын байгууламж сэтлэх, “Дарьганга” зочид буудал руу орох авто замын гарц гаргахаар Ди жи френдс ХХК-аас ирүүлсэн хүсэлтийг аймгийн Засаг даргын 2019 оны А/627 дугаар захирамжаар байгуулагдсан “Инженерийн шугам сүлжээг шинээр угсрах, засварлах, өргөтгөх зорилгоор авто зам сэтлэх, орц гарц гаргах зөвшөөрөл олгох” ажлын хэсгийн 04 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн зөвшөөрөл олголоо.

Энэ сард 357 тээврийн хэрэгсэл техникийн хяналтын үзлэгт хамрагдсан дүн мэдээтэй байна. Зорчигч тээвэр: Улаанбаатар хотоос Сүхбаатар аймаг чиглэлд автобусаар 1028 зорчигч, Сүхбаатар аймгаас Улаанбаатар хот чиглэлд автобусаар 1374 зорчигч зорчсон байна.

Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын тээвэрлэлтийн үйл ажиллагааг эхлүүлэх бэлтгэл ажлын хүрээнд аймгийн Онцгой байдлын газар, Эрүүл мэндийн газар, Автотээврийн төв, Мэргэжлийн хяналтын газар, Тагнуулын хэлтсийн хамтарсан ажлын хэсэг 04 дүгээр сарын 18-ны өдөр Сүхбаатар сумын нутагт байрлах “Олгой булаг” ХХК, “Нагааранз” ХХК, “Алаг тогоо” ХХК, Уулбаян сумын нутагт байрлах “Эм Эл Цахиурт Овоо” ХХК-уудад Монгол улсын шадар сайдын “Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын тээвэрлэлтийн үйл ажиллагааг онцгой нөхцөлд зохион байгуулах түр журам”-ын хэрэгжилт, МХЕГ-ын улсын байцаагчаас өгсөн зөвлөмжийн биелэлттэй газар дээр нь танилцаж, бэлтгэл бэлэн байдал хангалтгүй байгаа тул холбогдох үүрэг даалгавар, зөвлөмж чиглэлийг дахин өгсөн байна.

**Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр:** Аймгийн Засаг даргын А/96 дугаар захирамжийн дагуу Сүхбаатар аймгийн хэмжээнд ашиглаж, хадгалж буй химийн хорт болон аюултай бодисын мэдээллийн сан үүсгэх, гарч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор Мэргэжлийн хяналтын газар, Онцгой байдлын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, холбогдох байгууллагууд хамтран химийн бодис, аюултай хог хаягдлын хадгалалт, ашиглалтын байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг 13 сумын ЕБС, эмнэлэг, лабротори, мал эмнэлэг, уул уурхайн компаниудад хийж гүйцэтгэсэн.

Шалгалтын хүрээнд:

- Уул уурхай, сургууль, судалгаа шинжилгээний лабораторийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 3 объектод химийн бодисын хадгалалтын болон ашиглалтын үеийн аюулгүй байдлыг ханган ажиллах талаар 28 заалттай зөвлөмж өгч, 1 байгууллагын химийн бодисын ашиглалтын үйл ажиллагааг түр зогсоож, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.
- Сумдын ерөнхий боловсролын сургуулиудын химийн кабинетад 1980-1990 онуудаас хойш хадгалагдаж буй химийн хорт болон аюултай бодисын ихээр байна. Шалгалтаар ашиглалтын хугацаа нь дууссан, нэр хаяг нь тодорхойгүй, сав баглаа боодол нь идэгдсэн, талсжсан, ууршилт явагдах нөхцөл бүрдсэн давхардсан тоогоор 198 нэр төрлийн 15 тн химийн бодисыг нэг бүрчлэн тоолж, бүртгэл судалгааг гаргаж, бэлтгэсэн өрөөнд хийлгэн лацдаж, хадгалалтын аюулгүй байдлыг ханган ажиллах талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө зөвлөмж өгч ажиллалаа.

Мөн 1 аж ахуйн нэгжид Зөрчлийн тухай хуулийн дагуу 3000 нэгжээр торгох шийтгэл оногдуулсан байна.

- Эмнэлгийн аюултай хог хаягдлын асуудлаар холбогдох байгууллагуудын хамтарсан зөвлөмжийг эрүүл мэндийн төвүүдэд өгч арга зүйн заавар зөвлөмж өгч

аюултай хог хаягдлын нөхцөл байдалтай танилцлаа. Шалгалтаар ихэнх сумдад аюултай хог хаягдлын ариутгах автоклуб байхгүй, зориулалтын байгууламж байхгүй, хогийн цэг дээрээ ил задгай хаяж байгаа ноцтой зөрчил илэрсэн тул ариутгалын автоклабыг стандартын дагуу барих, тохижуулах заавар зөвлөмж өгч ажилласан. Сумдаас Онгон сум автоклубтай, Түвшинширээ, Сүхбаатар сумд аюултай хог хаягдлын байгууламж нь стандартад дүйцэхүйц байсан.

**Сэг, зэмийн цэвэрлэгээ, эзэнгүй хог хаягдлын талаар:** Аймгийн хэмжээнд үхсэн малын сэг зэмийг цэвэрлэх, халдваргүйжүүлэх ажлыг 04 дүгээр сард кохион байгуулаж ажилласан. Үүнд: Баяндэлгэр сум-123, Баруун-Урт-380, Дарьганга-782, Сүхбаатар-10, Мөнххаан-1826, Наран-74, Түвшинширээ-4114, Халзан-33, Эрдэнэцагаан толгой нийт 5516 сэг зэмийг устгасан бөгөөд аймгийн хэмжээнд нийт 8 сум бүх нийтийн цэвэрлэгээ, сэг зэмийг устгал хийж 7560 сэг зэм устгасан бөгөөд бүх нийтийн цэвэрлэгээнд нийт 107 байгууллага, 2064 өрх хамрагдаж 227 тн хог хаягдлыг устгаж 3,8 сая төгрөг зарцуулсан байна.

**Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар:** Он гарсаар аймгийн хэмжээнд 3 удаагийн хээрийн түймэр гарч нийт 1365 га газар шатаж 9.391,160 төгрөгийн хохирол учирсан байна.

Наран Сумын 2-р багийн нутаг болох Баяндулаан уулын зүүн цард 04 сарын 16-ны өдөр хүний буруутай үйл ажиллагааны улмаас ой, хээрийн түймэр гарч 1250 га шатсан байна.

Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах ажлыг эрчимжүүлэх тухай БОАЖС-аас өгсөн чиглэлийн дагуу аймгийн Онцгой байдлын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Мэргэжлийн хяналтын газар, холбогдох байгууллагууд хамтран хээрийн түймрийн эрсдэл бүхий газарт амьдардаг малчид, мал бүхий 32 өрх, 84 иргэдэд "Хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх" санамж, сэрэмжлүүлэг тарааж, болзошгүй эрсдэлээс сэргийлэх талаар зөвлөмж өгч ажиллалаа.

Мөн түймэр гарах эрсдэлтэй ихтэй сумдын ЗДТГ-т эхний ээлжинд 100 ширхэг гарын авлага өгч байгаль хамгаалагч нараар дамжуулан иргэдээс гарын үсгийн баталгаа авах, орон нутгийн телевизээр иргэд рүү чиглэсэн нөлөөллийн ажлуудыг үе шаттайгаар зохион байгуулах зэрэг ажлуудыг хэрэгжүүлж байна.

**Ойн талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:** "Аймгийн төвийн ногоон байгууламжинд тарьсан модны усалгаа, арчилгааг хийж ургуулах" ажлыг 50 сая төгрөгөөр гүйцэтгэх ажлын тендерийг зарлаад байна. Нийт 16 байршил бүхий газруудад ургаж байгаа 22.665 ш мод сөөгний усалгаа, арчилгааны ажлын тендерийг 4 багцтайгаар зохион байгуулахаар зарлаж тендерийн нээлтийг хийсэн ба 3 аж ахуйн нэгж 5 үнийн саналыг ирүүлсэн.

**Усны нэгдсэн менежментийн бодлогыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:** Баруун-Урт голын хашаа хамгаалалтыг үргэлжлүүлэн шинэчилж, дуусгах 28.8 сая төгрөгийн тендерийн зарлаж шалгаруулалтыг хийсэн ба "Хот тохижилт" ОНӨААТҮГ уг тендерт шалгарсан байна.

УГХДТСГЗахиргаатай хамтран Дэлхийн усны өдрийг тохиолдуулан аймгийн хэмжээнд ЕБС-ийн дунд, ахлах ангийн сурагчдын дунд "Ус ба уур амьсгалын өөрчлөлт" зохион бичлэгийн уралдааныг зарлахад нийт 35 сурагч оролцлоо. Ангилал тус бүрд эхний 3-н байр, нийт 6 хүүхдийн зохион бичлэгийг шалгаруулж, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагналаа.

Холбогдох хууль, тогтоомж, бичиг баримтын бүрдлээр 14 худагт худгийн зөвшөөрөл олгосоны зэрэгцээ БОНБУ-ний тухай хуулийн дагуу байгаль орчинд нөлөөлөх ерөнхий үнэлгээний дүгнэлт-2 аж ахуйн нэгжид боловсруулан батлуулсан. 4 аж ахуйн нэгжид БОМТөлөвлөгөөний талаар зөвлөгөө чиглэл өгч, БОМТ-г батлуулан, 2 аж ахуйн нэгжийн төлөвлөгөөнд тусгагдсан зардлын 50%-ийг Баруун-Урт сумын нэмэлт дансанд 1.1 сая төгрөг барьцаа хөрөнгөөр төвлөрүүлээд байна.

**Газар, газрын хэвлийн төлөв байдлын талаар авч хэрэгжүүлсэн ажил:** Сүхбаатар, Эрдэнэцагаан сумын заагт хууль бусаар ашигт малтмал хайж ашиглах үйл ажиллагааг аймгийн Цагдаагийн газар таслан зогсоож, орон нутгийн зүгээс техникийн нөхөн сэргээлтийг хийлгэн сум орон нутгаас тус газарт хамгаалалтын пост гарган ажиллаж байна.

БОАЖС-ын 2020 оны 03 дугаартай албан даалгаврын хүрээнд үйл ажиллагаа явуулсан газартаа нөхөн сэргээлт хийлгүй орхисон, үүрэг хариуцлагаа биелүүлээгүй Нанжид ХХК, Бигэр мандал ХХК, Бага өлгий ХХК –уудын мэдээллийг Цагдаагийн газарт хүргээд байна.

Иргэдэд БО-ны чиглэлийн мэдээг BBS тв, Сүхбаатарын өнгө, байгууллагын фейсбүүк хуудсаар дамжуулан иргэдэд хүргэж байна. 04 дүгээр сард BBS тв-д 3 мэдээ, Ой, хээрийн түймрээс урьдчилэн сэргийлэх 5 шторк, фейсбүүк хуудсаар дамжуулан 23 нийтлэлтийг давхардсан тоогоор 9801 иргэнд хүргэж ажилласан байна.

### **Зургаа. Бусад салбарт хийгдсэн ажил:**

**Мэргэжлийн хяналтын газар:** Тус газраас Түмэнцогт суманд 6 хяналтын чиглэлээр төлөвлөгөөт хяналт шалгалт хийж зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн.

Түмэнцогт сумын 1 эрүүл мэндийн төв, 2 эмийн санд шалгалт хийгдсэн. Шалгалтаар 42 зөрчил илрүүлж, 10 зөрчлийг арилгуулж хугацаа шаардах зөрчлийг арилгуулахаар 32 заалттай 3 албан шаардлага хүргүүлж, Эрүүл мэндийн төвөөс илэрсэн 7 нэр төрлийн эм, эмнэлгийн хэрэгслийн хураах 1 акт үйлдсэн.

Мэргэжлийн хяналтын газрын даргын баталсан 17/24 тоот удирдамжийн дагуу Түмэнцогт сумын Эрүүл мэндийн төвийн хоол үйлдвэрлэлийн үйл ажиллагааг 1.10.2 кодтой хяналтын хуудсаар 33.0 хувийн дунд, Жи Грайн ХХК-ний 24 хүнсний дэлгүүрийн үйл ажиллагааг 1.11.1 кодтой хяналтын хуудсаар 36.5 хувийн дунд эрсдэлтэй үнэлэгдэж улсын байцаагчийн 18 заалттай 2 албан шаардлага хүргүүлэн биелэлтэд хяналт тавьж байна.

Уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 1 ААН-д төлөвлөгөөт бус шалгалт хийж ус ашиглалтын үйл ажиллагааг түр зогсоосон.

МХЕГазрын дэд даргын өгсөн үүрэг чиглэлийн дагуу гол нэрийн 8 хүнсний бүтээгдэхүүний судалгааг 100 м<sup>2</sup> бага 15 хүнсний дэлгүүрээс авч нэгтгэн МХЕГ-т хүргүүлээ.

2020 оны хаврын тариалалтын, уринш, хөрс боловсруулалт, тарималын үрийн чанар, аюулгүй байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хийж дүн мэдээг МХЕГ-т хүргүүлж ажиллалаа.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын баталсан 01/73 тоот удирдамжийн хүрээнд 3 мансууруулах сэтгэц нөлөөт эмээр үйлчилж буй 2 эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн чанар аюулгүй байдлыг хангах, энэ төрлийн эмийн буруу түгээлт, зарцуулалтыг таслан зогсоох, үүсч болзошгүй эрсдэлээс сэргийлэх зорилгоор урьдчилан сэргийлэх шалгалт хийгдсэн.

МХЕГазрын даргын баталсан 01/22 тоот удирдамжийн дагуу 3 ус цэвэршүүлэх үйлдвэр, 2 талх нарийн боовны цехийн бүтээгдэхүүн савлагааны хуванцар сав болон нийлэг уутнаас шинжилгээнд 5 дээж авч лабораторийн шинжилгээнд аваад байна.

МХЕГазрын даргын өгсөн чиглэлийн дагуу худалдаа үйлчилгээний газруудад цагийн хуваарийн мөрдөлтийн байдалд урьдчилан сэргийлэх шалгалтыг 46 иргэн, аж ахуй нэгжид тоон мэдээллийг нэгтгэн цахимаар ХАБХХААГазрын Хүнсний чанар, стандартын хяналтын улсын ахлах байцаагч Н.Ургамалд 4 сарын 16-нд хүргүүлсэн.

Баруун-урт суманд барилга угсралтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 65 ААН-д 19 заалттай 2 албан шаардлага өгч гарч болох эрсдэл, аюулгүй байдлын талаар зөвлөмж чиглэл өгч ажилласан. Уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 4 ААН-д онцгой нөхцөлд эрдэс баялаг тээвэрлэхтэй холбоотойгоор бэлтгэл ажлыг шалгаж, коронавирүсээс сэргийлэх талаар зөвлөмж чиглэл өгсөн.

Улсын ерөнхий байцаагчийн 01/16 тоот удирдамжийн дагуу сумдын сургуулиудад хадгалж байгаа химийн хорт бодис болон аюултай бодисын хадгалалтын байдалд урьдчилан сэргийлэх хяналт хийж, хадгалалтын аюулгүй байдлыг хангах талаар 24 заалттай зөвлөмж өгч устгах шаардлагатай бодисын судалгааг гаргаж МХЕГ-т хүргүүлсэн.

Мэргэжлийн хяналтын газрын даргын баталсан 17/07 зөвлөн туслах хөтөлбөрийн дагуу Баруун-Урт сумын “Өсөх дэлгэр ундрах” ХХК-ний “Ундрах” талхны цех, Х.Хатанбаатар эзэнтэй “Ансар хэрчсэн гурил”-ын цехийн үйл ажиллагаанд 1.7.1 кодтой хяналтын хуудсаар үнэлгээ хийхэд дунджаар 46.4 хувийн дунд эрсдэлтэй үнэлэгдэж 23 заалттай 2 зөвлөмж гарган хүргүүлээд байна.

Мөн Түмэнцогт сумын “Өглөгч Ачтан” ХХК-ний “Буяаннэмэх” хүнсний дэлгүүрийн үйл ажиллагаанд зөвлөн туслах үйлчилгээ 1.11.1 кодтой хяналтын хуудсаар үнэлэхэд 24 хувьтай бага эрсдэлтэй үнэлэгдсэн байна.

2020/04/08-13-ны өдрүүдэд Бичигт боомт дээр ажиллаж ариутгалын түр пунктийн үйл ажиллагаа болон онцгой нөхцөлд хийгдэх тээвэрлэлтийн үйл явцтай танилцан зөвөлгөө зөвлөмж өгч ажиллав.

Мэргэжлийн хяналтын газраас “Маскаа зүүцгээе аян”-ыг бусад төрийн байгууллагуудад уриалан чөлөөт өрнүүлэн ажиллаж байгаа бөгөөд аяны хүрээнд 12 заалттай төлөвлөгөө гарган “Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах баг”-т хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын хүрээнд Баруун-Урт сумын 8 багийн 20 хүүхдийн тоглоомын талбайд эрүүл ахуй, хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч нар хамтран тандалт судалгаа хийж, хүүхдүүд болон эцэг эхчүүдэд зөвлөгөө, зөвлөмж өгч ажиллалаа.

МУ-ын Засгийн газрын 2019 оны "Хурдан морины уралдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 57 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2019 "Хурдан морины уралдаан зохион байгуулахыг хориглох тухай" А/89 дүгээр захирамжаар жил бүрийн 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 5 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд аймгийн нутаг дэвсгэрт хурдан морины уралдаан, үсэргээ, сунгаа зохион байгуулахыг хориглосон шийдвэрийг Сумдын засаг даргын тамгын газар, Морин спорт уяачдын холбоо, нийт уяач, морь сонирхогч иргэдэд улсын байцаагчийн 10 заалттай зөвлөмжийг хүргүүлж ажилласан.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 01/01 албан даалгаврын хүрээнд эрүүл мэндийн байгууллагуудын бэлэн байдлыг хангуулах дэмжлэгт хяналт хийх зорилгоор аймгийн хэмжээнд үйл ажиллагаа эрхэлж байгаа 30 эм хангамжийн байгууллагын эм, эмнэлгийн хэрэгсэл 2020.03.18-ны өдрийн байдлаар нэн шаардлагатай эмийн хангалт -73.63%, эмнэлгийн хэрэгсэл-71.37%, хамгаалах хувцас хэрэгсэл-53.02%, ариутгалын бодис -43.56%-ийн хангалттай байгаа тул дор бүрнээ хангалтаа нэмэгдүүлж ажиллах болон чанар аюулгүй байдал дээр заавар зөвлөгөө өгсөн.

Мэрси Кор олон улсын байгууллагаас коронавирүсийн халдвараас урьдчилан сэргийлэх ажилд дэмжлэг болгон аймгийн Онцгой байдлын газарт 4,5 сая төгрөгийн өртөг бүхий эд материал, аймгийн Мал эмнэлгийн газарт шатахууны дэмжлэг үзүүллээ.

Малын сэг зэм цуглуулах, устгах, орчныг халдваргүйжүүлэх ажилд дэмжлэг болгон аймгийн Мал эмнэлгийн газарт 1,3 сая төгрөгийн шатахууны талонь гардуулан өглөө.

Энэхүү дэмжлэг нь АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагийн тусламжтайгаар Мерси Кор Монгол байгууллагаас хэрэгжүүлж буй "Гамшигийн эрсдэлийг бууруулахад Уламжлалт болон Шинжлэх ухааны аргыг ашиглах нь" төслийн хүрээнд хийж буй ажил юм.

### **Долоо. Сумдад зохион байгуулагдсан ажил:**

#### **Асгат:**

**Төрийн удирдлагын чиглэлээр:** ИТХ-ын тэргүүлэгчид 2 удаа хуралдаж сонгуулийн хэсэг байгуулах, зурагт самбар ухуулах хуудас байрлуулах зэрэг асуудлуудыг хэлэлцлээ.

Сумын ЗДТГ-аас Маскжуулах аяны хүрээнд төсвийн байгууллагууд болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдтэй хамтран 470 ширхэг амны хаалтыг оёж байгууллагын багш, ажилчдад түгээн ажилласан ба гадуур маскгүй иргэд, хүүхдэд түгээж халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зөвлөмжийг хүргэн ажиллаж байна.

ЕБСургууль, Цэцэрлэгийн хамт олон сумын онцгой комисст 500,0 мянган төгрөгний хандив, 3-р багийн малчин Д.Эрдэнчулуун 1,0 сая төгрөгний хандивыг тус тус өгсөн .

**Хөдөө аж ахуйн чиглэлээр:** Ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг гэр хорооллын айл өрхийн муу усны нүх, жорлон 720м<sup>2</sup> нийтийн эзэмшлийн талбай 34,000м<sup>2</sup> хашаа хороо 285 , малын хүүр сэг зэм 633 , нийт 110252 м<sup>2</sup> талбайд ариутгал халдваргүйжүүлэлтийг хийж гүйцэтгэсэн.

Мал амьтны сэг зэмийг устгах, халдваргүйжүүлэх ажилд оролцсон. Үүнд 24 бог 10 бод малыг тусгай нүхэнд хийж ариутгал халдваргүйжүүлсэн.



Мал төллөлт 70 хувь ингэ 20, гүү 2200, үнээ 2170, хонь 29770, ямаа 17500 бүгд 51660 эх мал төллөсөн төл бойжилт 95 хувьтай байна. Малын зүй бус хорогдол бүгд 559 адуу 32, үхэр-24, хонь-225, ямаа-275

**Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт:** Ахмадын сувилалд 6 ахмад настанг амрааж, Бүлгээр ногоо тарих, хоггүй орчинд мод таръя 2 төсөл хэрэгжихээр болсон. Зорилтот бүлгийн 10 иргэнээр 2 өдөр сумын төвийн ойр орчмын хог түүх ажлыг гүйцэтгүүлэв.

**Боловсрол:** 04 сарын 27-ны байдлаар нийт 242 сурагчдаас 185 суралцагч буюу 76,4% -нь , бага боловсрол 73,6%, суурь боловсрол 80,9% -тай байна. Өмнөх долоо хоногийн хичээл үзэлтээс 11,6 % -иар буурсан байна. Сургуулийн нээлттэй ба хаалттай группэд эцэг эх, суралцагчдад зориулсан мэдээ, мэдээллийг зөвлөмж, санамжийг боловсруулан хүргэсэн. сурагч цахим хичээлийг үзэж, судлаж байгаа бөгөөд сурагчдын 91,3% нь хамрагдаж байна. Бусад сурагчидтай холбогдох боломж үгүй байна.

Аймгийн Засаг даргын захирамжийн дагуу " Хамгаалагдсан хүүхэд-Хариуцлагатай эцэг, эх " 14 хоногийн аян зохион байгуулж багш ажилтнууд эргүүл хийх , санамж зөвлөгөөг жолооч нарт тараах зэрэг ажлыг зохион байгуулсаны зэрэгцээ маскаа зүүх шаардлага тавин, маскгүй яваа 40 иргэнийг маскжуулав.

### **Баруун-урт:**

#### **Байгаль орчин, хот төлөвлөлт, газар зохион байгуулалтын чиглэлээр:**

Коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд "Цэмцгэр - Баруун-Урт" хотод амьдаръя" уриатай бүх нийтийн их цэвэрлэгээг 4 дүгээр сарын 3-аас 12-ны өдрүүдэд зохион байгууллаа. Бүх нийтийн цэвэрлэгээний ажилд 37 иргэнийг ажиллуулж, түр ажлын байраар хангасан. Сумын хэмжээнд нийт 120м3 хог цэвэрлэж, хогийн цэгт асгасан. Нийт 4477740 төгрөгийн зарцуулсан.

Гамшгаас хамгаалах сэрээн дохион сургуулилалтыг ЭМЯ, Улсын онцгой комиссын зөвлөмжийн дагуу газар хөдлөлтийн гамшгаас сэргийлэх цахим уриалгыг явуулж ажилласан. Газар хөдлөлтийн гамшгаас сэргийлэх цахим уриалгад 3072 иргэний хандалт авсан.

Коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, урин дулаан цаг ирж байгаатай холбоотой орчны эрүүл ахуйг бүрдүүлэх зорилтуудын хүрээнд сумын хэмжээнд бүх нийтийн ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг 4 дүгээр сарын 6-аас 12-ны өдрүүдэд зохион байгуулсан. Нийт 1,570,000 м<sup>2</sup> талбайд ариутгал халдваргүйжүүлэлт хийсэн.

Баруун-Урт сумын Засаг даргын Тамгын газар, онцгой комиссоос корона вирусийн дэгдэлтээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх арга хэмжээний хүрээнд тус суманд үйл ажиллагаа явуулж буй цэцэрлэг, сургуулиудтай хамтран ХАМТДАА СЭРГИЙЛЬЕ аяныг энэ сарын 10-20-ны өдрүүдэд зохион байгуулж 23 тоглоомын талбайд анхааруулга, мэдээллийн салбар байршуулсан.

Мэдээлэл түгээж ажилласан 20 автомашинд сэрэмжлүүлэг мэдээлэл байршуулж хөдөлгөөнт анхааруулга хүргэсэн.

Сумын ЗДТГ-ын албан ёсны сайт болох [www.baruun-urt.su.gov.mn](http://www.baruun-urt.su.gov.mn) болон [www.facebook.com/BUZDTG](https://www.facebook.com/BUZDTG) фэйсбүүк хуудсаар дамжуулан аяны тухай болон корона вирусээс сэргийлэх сэрэмжлүүлэг мэдээлэл хүргэсэн.

Сургууль, цэцэрлэгийн 902 /давхардсан тоогоор/ албан хаагч ажиллаж нийт 7277 иргэнд сэрэмжлүүлэг брошур өгч, зөвлөгөө мэдээлэл хүргэсэн.

Сумын нутаг дэвсгэрт байгаа мал бүхий 66 айл өрхийн 412 мал байгаа судалгааг гаргаж, мэдэгдэл хүргүүлсэн.

**Цаг үеийн ажлууд:** Тамгын газар, багийн ажлын албыг сурталчилах зорилгоор "Оюутан нэг өдөр " өдөрлөг зохион байгуулсан. Өдөрлөгийн хүрээнд оюутануудтай хамтран "ЧАМД ХАЙРТАЙ" аян зарлаж, 310,000 төгрөгийн үнэ бүхий витамин, амин дэмийг зорилтот бүлгийн иргэдэд тараасан.

Covid 19 вирусээс урьдчилан сэргийлэх үүднээс хэрэгжүүлж байгаа төрийн бодлогыг хэрэгжүүлэх, олон нийтэд хүргэх ажлыг Тамгын газрын цахим хаяг болон багуудын цахим хаягаар тогтмол хүргэж байна. Тухайлбал тайлант сарын хугацаанд Тамгын газрын цахим хуудсаар 27 мэдээллийг тогтмол шэйртэйгээр түгээсэн бөгөөд нийт мэдээллийн дундаж хандалт энэ хугацаанд 1600 үзэлт авсан байна.

Цаг үеийн мэдээллийг иргэдэд хүргэх зорилгоор 7 хоног тутмын хэвлэлийг багийн ажлын албаар дамжуулан 586 ширхэгийг тараасан. Үүнд: Сүхбаатарын өнгө, Ардчилал таймс, Ураг удам гэх мэт.

2020 оны 1-р ээлжийн цэрэг татлагад хамрагдах 634 иргэнээс 210 иргэнд буюу 33 хувьд нь зарлан дуудах хуудас хүргүүлээд байна.

Тус сумын 9 багийн малчин, мал бүхий 1179 өрхийн 124622 мянган толгой малын 49,8 тн, 11 аж ахуйн нэгжийн 1133 мянган толгой малын 453 кг ноолуур бэлтгэсэн судалгааг гаргаж ХХААГ-т хүргүүлсэн.

Коронавирусээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Улаанбаатар хотын постод ажиллах эмч нарын хуваарийг шинэчлэн гаргаж мөрдүүлэн ажиллаж байна. Постод сургууль, цэцэрлэг ӨЭМТ-үүдээс нийт 8 эмчийг хуваарийн дагуу үүрэг гүйцэтгүүлэн ажиллуулж, иргэдэд мэдээлэл зөвлөмж өгч байна.

Сумын хэмжээнд Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газраас нийт 8 кейс ирж явцын үнэлгээ хийж ажиллалаа. Үүнд: гэр бүлийн хүчирхийллийн-2 кейс, хүүхэд хамгааллын 6 кейс ирж кейсийн явц 70%-тай, 2 кейсийг бүрэн хаасан байна

### **Баяндэлгэр:**

**Төрийн удирдлагын чиглэлээр:** ИТХ-ын тэргүүлэгчдийн хурлыг хийж цаг үеийн асуудлыг хэлэлцлээ. УИХ-ын сонгуулийн хуулийн дагуу сумын сонгуулийн хороог байгуулж бүрэлдхүүний нэрийг нь санал болгож аймгийн сонгуулийн хороонд хүргүүлээ.

“Алдарт эх”-ийн 2 дугаар зэргийн одонгоор шагнагдах 17 эхийн материалыг бүрдүүлэн аймгийн ИТХ-ын ажлын албанд хүргүүлж ажиллалаа.

**Тамгын газар:** /COVID-19/ халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор сумын Засаг даргын А/30 дугаар захирамжийн дагуу төрийн болон төрийн бус байгууллагууд, аж ахуйн нэгж, нийтийн эзэмшлийн талбай, тоглоомын талбай, гудамж, айл өрхүүдийн нүхэн жорлон болон муу усны нүх, хог хаягдлын цэг зэрэг газруудыг хэсэгчилсэн байдлаар цэвэрлэгээнд хамруулж ариутгал халдваргүйтэлийг 2020 оны 03 сарын 27-ны өдрөөс 7 хоногийн хугацаанд зохион байгуулсан.

Ноолуурын үнийн уналтаас хамгаалах, малчдын орлогыг тогтвортой байлгах зорилгоор сумын засаг даргын 2020 оны А/38 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг малчдаас ноолуур худалдан авах ажиллагааг энэ сарын 22- 24- ний өдрүүдэд зохион байгуулж ХХААХҮЯ-тай гэрээ байгуулсан компаниудын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллалаа.

Сумын Засаг даргын 2020 оны А/40 дүгээр захирамжаар ээлжит цэрэг татлагын 1 дүгээр ээлжийг 04 дүгээр сарын 24-ний өдөр зохион байгууллаа.

**Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:** “Өөрийнхөө болон бусдын төлөө амны хаалтаа зүүцгээе” аяныг улс орон даяар зохион байгуулж байгаатай холбогдуулан цахимаар уриалга мэдээлэл зөвлөмжийг өгч ажиллаж байна.

Мөн албан байгууллага аж ахуй нэгж иргэдэд өөрсдөө амны хаалтаа хийж зүүх уриалга гарган ажилласан.

**ЕБСургууль:** Хорио цээрийн үеийн цэвэрлэгээний 7 хоног аянд ЕБС-ийн багш нар сумын Орлой гудамжийг хариуцан гаднах цэвэрлэгээг зохион байгуулан ажилласан. Багш нарт тухайн гудамжны 16 эгнээг хариуцуулж хуваарилан, хариуцсан эгнээнийхээ айл бүрийг цэвэрлэгээнд гаргах, тухайн хариуцсан өрхүүдийн аюулгүй байдал, сурагчдын хичээл үзэлт хийлтэд давхар хяналт тавих үүргийг өгч, иргэдэд зөвлөгөө зөвлөмж өгүүлж ажилласан. 169 өрх айлын 137 өрх өөрсдөө, 25 эзгүй айлыг багш нар өөрсдөө цэвэрлэлээ.

COVID-19-өөс урьдчилан сэргийлэх зорилгоор ЕБС-ийн захиргааны зүгээс 12 ангийн 57 сурагч, багш ажилтан 94, нэг удаагийн маскийг хүн бүрт 3 ширхэгийг тараасан.

**Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр:** Хөдөлмөр эрхлэлтийн LMIS программд 10 иргэнийг бүртгэн зуучлан ажлын байрыг мэдээллийн нэгдсэн системд бүртгэсэн.

Төсөл хөтөлбөрүүдийн мэдээллийг цахим болон банк, дэгүүрүүдээр зарлалыг нааж иргэдэд мэдээлснээр ахмад мэргэжилтний дэмжих хөтөлбөрт-3, ажлын байрыг дэмжих хөтөлбөрт-6, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг дэмжих хөтөлбөрт-3 төслүүдийг авч ХХҮГазарт хүргүүлсэн.

Хөдөлмөрийн аюулгүй байдлын аян зарлагдаж жолооч, үсчингүүд болон барилга байгууламж баригдаж байгаа газруудад гарын авлага тарааж ажиллалаа.

**Нийгмийн халамжийн чиглэлээр:** Цаг үеийн ажил үйлчилгээтэй холбоотой Халамж,цалинтай эх, жирэмсэн эхийн тэтгэмжүүд цаг хугацаандаа олгогдсон. Хүнсний эрхийн бичгээр үйлчлүүлдэг 62 өрхөд 36200000 төгрөгний хүнсний бүтээгдэхүүнийг олгосон.

Засаг даргын тамгын газар зорилтот 3 өрхөд тус бүр 218000 мян.төгрөгний хүнсний бүтээгдэхүүн олголоо.

**Эрүүл мэндийн төв:** Багийн эмч нар айл өрхөөр явж урьдчилан сэргийлэх үзлэг, ЭМЯ-аас өгч буй COVID-19 халдварын талаархи зөвлөмжүүдийг хүргэн ажилласан. Мөн 243 айл өрх, 23 аж ахуй нэгж, албан байгууллагуудын нийт 2235 м/кв талбайд ариутгал халдваргүйжүүлэлт хийж, заавар зөвлөмжийг тараасан.

“ЗАЙ БАРЬ” /2м/ наалтыг 2 төрлийн 6 ш бэлтгэж амбулатори больницын орох гарах хэсэг болон коридоруудад байршуулав. Энэхүү санамжийг аж ахуй нэгж, албан байгууллагын 17 газарт байршуулсан.

Цагдаагийн тасагтай хамтран “Жолооч нарт өгөх зөвлөмжийг 47 жолоочид тарааж, амны хаалтгүй 15 жолоочид амны хаалтаа байнга зүүж өөрийгөө болон гэр бүлээ хамгаалахыг зөвлөсөн. “Бид маскаа авах болоогүй Хайртай бүхнийхээ төлөө маскаа зүүцгээе” уриалгыг хийж эрүүл мэндийн төвөөр орох хэсэгт байрлуулав.

Covid-19 халдвараас сэргийлэх зөвлөмжийг 415 хүнд тарааж, гарыг нь ариутгуулан, амны хаалтгүй хүнийг амны хаалтаа зүүхийг шаардан ажиллаж байна. Мөн иргэдийн хөл хөдөлгөөн ихсэж дэлгүүрүүдийн худалдан авалт нэмэгдэж байгаатай холбогдуулан бараан дээр нь халдвараас сэргийлэх зөвлөмжүүдийг нааж байна. Дэлгүүр болон зоогийн газруудаар явж 656 ш зөвлөмж наасан.

**Цэцэрлэг:** Багш нар бүлгийн хүүхдүүдэд номын богц аялуулж байна. Маск зүүцгээе аянд байгууллага хамт олноороо нэгдэж ноолуур авч байгаа болон цэрэг татлага болж байгаа газруудад 100ш гарын авлага 35 ширхэг маск тараалаа.

Боловсролын хүрээлэнгээс теле хичээлийн тандалт судалгааг тус цэцэрлэгийн 50 эцэг эхээс авлаа.

**Хөдөө аж ахуйн чиглэлээр:** Цөм сүргийн 12 суурийн 69 эм ямаа, 31 охин шүдлэн, 3 шүдлэн ухна, 96 бүдүүн ухнаас хоолуурын дээж авч МААЭШ инжилгээний хүрээлэнд хүргүүлсэн.

АМЭ трэйд компианы 04 дүгээр сарын 22-25 ны өдрүүдэд 6 багийн 900 өрхийн 59,8 тн ноолуурыг худалдан авалт хийгдэхэд ХАА-н тасгийн мэргэжилтэнүүд хамтран ажилласан.

**Байгаль орчны чиглэлээр:** Сумын засаг даргын 2020 оны А/30 дугаар захирамжийн дагуу аж ахуй нэгж айл өрхүүд бүх нийтийн цэвэрлэгээнд хамрагдлаа. Нийт 8 байрны 565 айл өрхүүд хамрагдахаас түр эзгүй 154 айл өрхүүдийн хашааны ард, урд талуудыг хариуцсан байгууллагуудын албан хаагчид өөрсдийн хүчээр цэвэрлэсэн байна. Мөн 6 нийтийн эзэмшлийн газар, 21 ААНэгжүүдийг цэвэрлэгээнд хамруулан нийт 42 тонн хогийг хог зөөврийн машинаар нэгдсэн хогийн цэгт төвлөрүүлэн ажиллалаа.

Монгол Улсын Засгийн газар болон Улсын онцгой комиссын болон аймаг сумын онцгой комиссын шийдвэрийн дагуу сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг нийт албан байгууллага аж ахуй нэгж , айл өрхийн нүхэн жорлон нийтийн эзэмшлийн талбайд ариутгал халдваргүйтгэлийг хийж гүйцэтгэлээ.

### **Дарьганга:**

**Төрийн удирдлагын чиглэлээр:** Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийг шинэчилж 2022 оноос эхлэн мөрдөхтэй холбогдуулан хуулийн төсөлд сумын ИТХ, ЗДТГ-аас 9 саналыг авч аймгийн ИТХ-ын ажлын алба болон ТЗУХ-т тус тус хүргүүллээ.

Монгол улсын Улсын Онцгой комиссын 2020 оны 09 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын захирамж, аймгийн МХГ-ын зөвлөмж болон бусад холбогдох шийдвэрийн дагуу сумын Засаг даргын 2020.04.13 ны өдрийн А/35 дугаар захирамжаар “МАСКАА ЗҮҮЦГЭЭЕ” аяныг өрнүүлэн ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын 2020 оны А/263 дугаар захирамжийн дагуу “Хамгаалагдсан хүүхэд-хариуцлагатай аав ээж” арга хэмжээг 2020.04.13 -2020.06.13 ныг хүртэлх

хугацаанд зохион байгуулахаар сумын Засаг даргын захирамжаар төлөвлөгөө, удирдамж батлуулан ажиллаж байна.

**Хууль эрх зүйн сургалт сурталчилгааны чиглэлээр:** Долоо хоног бүрийн 5 дахь өдөр аймгийн Нийгмийн бодлогын хэлтэст корона вирусийн халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлж буй “ЦАХИМ СУРТАЛЧИЛГАА”-ны мэдээг хүргүүлж байгаа бөгөөд 4 дүгээр сард нийтдээ гурван долоо хоногт 6 байгууллагаас 145-220 мэдээллийг цахимд оруулж 649-1139 хүний хандалтыг авсан байна.

**Эрүүл мэнд:** Сумын ЭМТ-өөс 04 дүгээр сард цахим орчинд 130 сурталчилгааны баримтыг оруулж 1049 иргэний хандалтыг авсан. Мөн 6 төрлийн 410 ширхэг брошур тарааж, Ёс зүйн баг нь 2 төрлийн сургалтыг дотооддоо 2 удаа зохион байгуулж 25 албан хаагчийг хамруулсан.

ЭМТ-өөр үйлчлүүлэгч иргэд болох 132 иргэнд зөвлөгөө зөвлөмжийг хүргэж ажилласан. “Маскаа зүүцгээе” аяны хүрээнд 8 цэгт “Маскаа зүүх арга”, “Зай барь” санамжийг байршуулж, 25 иргэнд маск тараав.

- “Сайн үйлс арвилан дэлгэрэх” ТТБ-ын тэргүүн Дарьганга сумын уугуул Гомбын Эрдэнэбат сумын онцгой комисст амны хаалт 35ш, гар ариутгагч саннитол 24ш, витамин С 24ш гар ариутгагч, савангийн хананы сав 12 ш, нярайн өлгий даавууны иж бүрдэл 3ш-ийг тус тус хандивласан.

**Байгаль орчин:** Сумын Байгаль орчны хяналтын улсын байцаагч нь сумын төвийн эзэнгүй хогийг цэвэрлэх үйл ажиллагааны хүрээнд аймгийн ХХҮГ-т “Нийтийг хамарсан ажил” төслөөр 2 төсөл бичиж хүргүүлсэн нь шалгарч батлагдсан бөгөөд энэ чиглэлээр 7 хоногт өдрийн 28000 төгрөгийн цалинтай ажиллах иргэдийг шалгаруулж байна.

Энэ сарын 14 нд тус сумын 3 дугаар багийн нутагт хээрийн түймэр гарч 1250 га газар шатаж, 8268750 төгрөгийн хохирол тогтоосон бөгөөд нийт гарсан зардал 830900 төгрөг, бүгд 9,099650 төгрөгийн нэхэмжлэлийг хохирол учруулсан иргэнээс гаргуулахаар боллоо.

**Хөдөө аж ахуй:** МЭҮТ-аас цахим орчинд коронавирусээс урьдчилан сэргийлэх зорилгоор айл өрх, аж ахуйн нэгжийн нийт 180 нүхэн жорлон, муу усны нүхийг ариутгах ажлыг зохион байгуулж байна.

Сэг зэм устгах, булах, халдваргүйжүүлэх ажлын хүрээнд 62 бод, 750 бог, 55 нохойн сэг зэмийг нэгдсэн цэгт аваачин булж устгалаа.

2020.04.19 нөөс 21 ний өдрүүдэд цасан шуурга шуурч 3 дугаар багт 5 суурийн 910 мал, 2 дугаар багт 15 суурийн 905 толгой мал, нийтдээ 1815 толгой мал хорогдсон тул 100 боодол өвсийг хүргүүлэх арга хэмжээг авсан.

**Нийгмийн даатгал:** Малчин даатгуулагчийн ажилласан жилийг тодорхойлох зөвлөлийн хурлаар 5 иргэний өргөдлийг шийдвэрлэсэн

“Миний гэр аюулгүй орчин” уриалгыг дэмжиж албан байгууллага, аж ахуйн нэгж, иргэд нэгдэн үйл ажиллагааг зохион байгуулсан.

#### **Ерөнхий боловсролын сургууль, Цэцэрлэг, Соёлын төв:**

04 сарын 06-09-ний өдрүүдэд сумын ЕБС, Соёлын төв, ЭМТөв, Хүүхдийн цэцэрлэг хамтран хөдөөгийн малчдын хүүхдүүдийн теле хичээлийн хамрагдалт, хүүхдийн эрсдлийн судалгаа, хүүхдүүдэд уран зохиолын болон үлгэрийн номоор үйлчилэх, ардын тоглоом наадгай, угийн бичиг хөтлөлт, "Covid-19"- халдвараас урьдчилан сэргийлэх санамж зөвлөгөө зэрэг чиглэлээр хөдөөгийн багуудад хүрч ажиллаж байна.

2020.04.17-ноос "Хамгаалагдсан хүүхэд-Хариуцлагатай аав, ээж" нэгдсэн арга хэмжээний хүрээнд сумын ЕБС-ийн захиргаанаас "ОЛОН НИЙТИЙН ЭРГҮҮЛ"-ийг зохион байгуулах төлөвлөгөө гарган ажиллаж эхэллээ.

04 сарын 16-ны өдрийн 11:00-16:00 цагийн хооронд нийтийн эзэмшлийн зам талбай, гудамжуудад эргүүл хийн хүүхэд багачууд, эцэг эхчүүдэд өөрийгөө хэрхэн зөв хамгаалах, теле хичээлээ хэрхэн үр дүнтэй үзэж судлах чиглэлээр зөвлөмж, зөвлөгөө өгч ажиллалаа. Нийт 28 хүүхэд, 15 том хүн хамрагдсанаас, 63% нь амны хаалттай, 37% нь амны хаалтгүй байлаа.

#### **Мөнххаан:**

**Төрийн удирдлага зохион байгуулалтын чиглэлээр:** Улсын онцгой комиссын тогтоол, шийдвэрийн дагуу сумын онцгой комиссоос төлөвлөгөө гарган иргэдийг маск зүүх аянд нэгдэх үйлчилгээний байгууллагууд маскгүй иргэдэд үйлчлэхгүй байх, зай барих,

иргэдэд гарын авлага боршур тараах, цаасан хэлбэрээр санамж сэрэмжлүүлэг наах, цахим хуудсуудаар мэдээллийг видео хэлбэрээр түгээх, сайн дурын хөдөлгөөнт эргүүл гаргах зэрэг ажлыг 4/13- 4/20ныг хүртэлх хугацаанд ажиллуулсан. Бүх төсөвт байгууллагууд хамтран 500ш боршур тараах материалыг бэлтгэн иргэдэд тараах мөн узелиэр гудамж талбайд иргэдийг маск зүүхийг уриалах, гадуур сэлгүүцэхгүй байх, гараа сайтар угаах, орчны ариун цэвэр эрүүл ахуйг хангах талаар зөвлөмж чиглэлийг 16.00 цагт өдөр бүр эгнээ гудамжаар зарлаж танилцуулж байна.

Сайн дурын хөдөлгөөнт эргүүлд тамгын газар хүүхдийн цэцэрлэгээс төрийн албан хаагчдыг гарган иргэдэд маскаа зүү гэсэн шаардлагыг тавьж, гадуур бөөгнөрөл үүсгээд байгаа иргэдийг анхааруулж тараах, архи согтууруулах ундаа худалдан борлуулдаг аж ахуйн нэгжүүдийн цагийн хуваарьт хяналт хийх, худалдаа үйлчилгээ хоолны газруудыг 8.00 цагт хаалгах, Ковид 19 эсрэг хамтдаа автомашины гэрлийг асааж хөдөлгөөнд орох уриалгыг хэрэгжүүлж байна.

Сайн дурын хөдөлгөөнт эргүүл нийт 350 гаруй иргэдэд маск зүүх шаардлага тавьж тараах материал өгсөн. Иргэд амны хаалт тогтмол зүүх уриалгыг дэмжиж хүлээн авч байна.

2020 оны 1-р ээлжийн цэрэг татлагын ажил 04/26 нд явагдаж нийт 119 цэргийн насны залуучууд үзлэгт хамрагдсан. Засаг даргын ажлын олон нийтийн сүлжээгээр дамжуулан иргэдэд мэдээллсэн. Мөн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2019 онд хийгдсэн ажил болон 2020 онд хийх ажлуудыг видео хэлбэрээр бэлтгэн иргэдэд хүргэлээ.

**Хөдөө аж ахуй:** Ноолуур бэлтгэлийн ажлын хүрээнд аймгийн ХХААГ-т сумын 1030 ямаатай өрхийн судалгааг гаргаж хүргүүлсэн. Ноолуур авах цэгүүдэд хяналтын камер суурилуулж, бэлтгэл ажлыг хангуулан зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх ажлын хэсгийг сумын Засаг даргын А/49 дүгээр захирамжаар байгуулж ажил үүргийн хариуцуулж танилцуулан үүрэг чиглэлийг өгөн ажиллалаа.

Сумын төвийн гүн өрмийн 2 худгийг Ухаалаг худаг болгох ажил тендер сонгон шалгаруулалтаар Стайль орд ХХК шалгарч худаг тохижуулалт болон тоног төхөөрөмжийг суурьлуулах ажлууд хийгдэж дуусаад байна.

**Соёлын төв:** Номын сангийн явуулын үйлчилгээгээр 87 иргэнд 120 номоор үйлчлээд байна.

Орон нутаг судлах танхимыг тохижуулан тавих үзмэр мэдээ мэдээллийг цуглуулан ажиллаж байна.

### **Наран:**

“Амны хаалтаа зүүцгээе” аяны хүрээнд эргүүл ажиллуулж хяналт тавьж 100ш амны хаалтыг иргэд үнэгүй тараалаа.

Боловсрол, соёл: Хорио цээрийн дэглэмийг гэрийн нөхцөлд сахиулах, гэрийн нөхцөлд ахуйн осол болон “Ковид-19” өвчнөөс урьдчилан сэргийлэх зөвлөмжийг эцэг эх, сурагчдад хандсан зөвлөмж зөвлөгөөг сумын болон анги, бүлгүүдийн цахим хаягт байршуулж ажиллалаа.

Сурагчдын теле хичээл үзэлтэнд тандалт, судалгаа, үнэлгээ хийж ажиллахад нийт үзвэл зохих 231-ээс теле хичээл үзэж буй 184 сурагч, нийт хувь 79.6%-тай байна. Үүнээс бага боловсрол -82.1%, суурь боловсрол 74.3%-тай байна.

“Номын богц”-ыг аялуулж ЕБС-ийн нийт 10 сурагчид уншсан номынхоо гол дүрийг зургаар илэрхийлэх, сэтгэгдлээ бичих зэргээр хамтран ажилласан.

СӨБ-ийн 5 настай 40 суралцагчийн даалгаварын санг бүрдүүлж “Хүүхдээ хайрлаж хамгаалья” зөвлөмж, даалгаврыг үзэж, витаминжуулж, 76 эцэг эхээс санал асуулга авч ажилласан.

Номын сангаар 3 шинэ уншигч бүртгэж, 9 номоор үйлчиллээ.

Эрүүл мэнд: Сүхбаатар аймаг Наран сум нэртэй цахим хуудсанд “Covid-19 вирүсээс урьдчилан сэргийлэх”, “Маскаа тогтмол зүүх”, “Гараа тогтмол угаах”, “Дархлаагаа дэмжих”, “Таны эрүүл мэнд-Таны гарт” зөвлөмжийг байршуулсан.

“Нэг нь нийтийнхээ төлөө нийт нь нэгийнхээ төлөө”, “Бохирдох бүрт гараа угааж, амны хаалтаа зүүж, 2 метрын зай барьж яваарай, бусдад амны хаалтаа зүүх шаардлага,



хяналт тавьцгаая" "Маскаа зүүцгээе" аянд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгжүүд нэгдэж иргэдэд уриалга гаргалаа.

Олон нийтийн тоглоомын талбайд тандалт хийж, тоглоомын талбайд цугларсан бөөгнөрөл үүсгэж буй хүүхдүүдэд шаардлага тавьж, 2 төрлийн нийт-6ш сургалт сурталчилгааны материал байршуулж ажилласан.

"Коронавирус халдвараас урьдчилан сэргийлэх" наадаг зөвлөмж гаргаж хүнсний дэлгүүрүүдэд нийт 250ш, иргэдийг масктай үйлчлүүлэх, 2 метрийн зай барь гэсэн сануулгыг албан байгууллагууд байршуулсан.

**Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт:**Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр зарлагдсан төсөл хөтөлбөр"-ийн талаар сумын групп болон зар тавьж 25 иргэнд мэдээлэл өгч "Ажлын байрыг дэмжих хөтөлбөрт-2, Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ-1, зөвлөх үйлчилгээний төсөлд-1, хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрт-1, Зохион байгуулалттай ажлын байрыг дэмжих хөтөлбөрт-1 төслийг хүлээн авсан.

Ажил зуучлалаар 22 иргэнийг LIMS программд бүртгэсэн. Зорилтот өрхийн 2 иргэнийг 14 хоног эзэнгүй хог хаягдал түүх ажилд зуучлан Засаг даргын нөөцөөс 250000 төгрөгийн цалинжуулан ажиллуулж байна.

3-р багийн ганц бие өндөр настанд хамтарсан багийн төсвөөс байшингийн доторлогооны зардлыг шийдвэрлэж 567950 төгрөгийн зардлаар байшингийн доторлогоог хийлээ.

**Байгаль орчин:** Сумын 2-р багийн нутаг болох "Баяндулаан уул"-нд 04 дүгээр сарын 16-ны өдөр 15 цаг 30 минутад хүний буруутай үйл ажиллагааны улмаас хээрийн түймэр гарч сумын засаг даргын тамгын газар, төрийн байгууллагын 22 албан хаагч, 2 машин газар дээр нь очиж түймрийг 20 цаг 00 минутанд бүрэн унтраалаа. Нийт 1250 га газар түймэрт өртсөн. 446600 төгрөгийн зардал гарлаа.

Хаврын хуурайшилтын үе эхэлсэнтэй холбогдуулан сумын 1,2-р багийн айл өрх, заставд "Хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх заавар зөвлөмж"-ийг өгч 90 иргэнээс гарын үсгийн баталгаа авсан.

Нохой устгалын ажлыг хийж 11 нохойг устгаж хогийн цэгт хаяж ариутгал хийлээ 150.000 төгрөгийн зардал гарсан.

"Эрүүл хоггүй цэвэр орчин"-г бүрдүүлэх зорилгоор бүх нийтийн их цэвэрлэгээг зохион байгуулж их цэвэрлэгээнд 6 албан байгууллагын 80 гаруй албан хаагч, иргэд хамрагдаж 800 га газраас 20 тонн хог хаягдлыг цэвэрлэж хогийн цэгт хаясан.

**Мал эмнэлэг:** Сумын засаг даргын 2020 оны А/25 дугаар захирамжаар "Ариутгал халдваргүйтгэл"-ийн арга хэмжээг 03 дугаар сарын 17-ны өдрөөс хийж байна.

Албан байгууллага, спорт заал, хүнсний чиглэлээр худалдаа үйлчилгээ эрхлэгч 6 аж ахуй нэгж, эмийн сангийн ойр орчим, гахай шувууны байр, хашаа хороо, өтөг бууцанд нийт 87234 мк талбайд ариутгал халдваргүйтгэл хийж 204750 төгрөгийн зардал гарсан. Мөн зорилтот бүлгийн 20 айл өрхийн хашаанд үнэ төлбөргүй ариутгал халдваргүйжүүлэлт хийлээ.

### **Онгон:**

**Тодөөг баяндаагүй аажуу өсөөгүй:** Маскаа зүүцгээе аяны хүрээнд сумын Засаг даргын А/37 дугаар захирамж гарч албан байгууллага, ард иргэдэд амны хаалт зүүхийг уриалж ажиллалаа.

Сумын төвд 2019 онд үйл ажиллагаа нь эхэлсэн 160 хүүхдийн бага сургуулийн барилгын ажлын гүйцэтгэл явцад ЕБСургууль, ЗДТГ-ын төлөөллийг оролцуулсан ажлын хэсэг хяналт тавин ажиллаж байна.

1-р шатны үзлэгт тэнцсэн цэргийн насны 16 иргэнийг дараачийн шатны үзлэгт оруулахаар боллоо.

**Ажлаан:** Сургууль цэцэрлэгийн сурагчдын цахим хичээл үзэлт, үзэж байгаа болон тэмдэглэл хийж байгаа эсэхэд байнга хяналт тавьж хөдөөгийн 20 өрхөөр түүврээр хяналт хийсэн. Хяналтаар хөдөөгийн малчдын хүүхдүүд цахим хичээлийг үзэхгүй байгаа гэсэн дүгнэлт гарсан.

Эрүүл мэнд: Сум дундын эмнэлгээс хөдөөгийн 3 багийн малчин өрхөөр ажиллаж коронавируст халдвараас хэрхэн сэргийлэх тухай сургалтуудыг 1 удаа зохион байгуулж хөдөөгийн 87 хот айлаар явж ажиллалаа.

**ᠣᠨᠠᠭᠤ ᠠᠭᠤ ᠠᠳᠤᠨ, ᠠᠠᠭᠠᠠᠠᠭᠤ ᠶ᠋ᠢᠨᠠᠭᠤ:** Ноолуур худалдан борлуулах ажлын хүрээнд 2 аж ахуй нэгж ирж ажиллаж байна. Сумын хувьд нийт 2019 оны жилийн эцсийн тоогоор 90 гаруй мянган ямаа тоологдсон бөгөөд 30 тонн ноолуур бэлтгээд байна. Эхний ээлжинд хөдөөгийн 3 багийн ноолуурыг авч байгаа бөгөөд одоогоор 3-р багийн иргэд ноолуураа бүрэн өгөөд байна.

Ариутгал халдваргүйтгэлийн ажилд 15 хүн 2 тээврийн хэрэгсэл, 2 малын эмч ажиллаж, сумын төв болон хөдөөгийн 22 хот айлын 40 малын сэг зэм, 35 золбин нохойг устгаж ариутгал халдаваргүйтгэл хийсэн.

Үлийн цагаан огтоно устгах, сумын төвийн хог хаягдлыг бууруулах төслүүдийг бичиж аймгийн ХХААГазар, ХХҮХэлтэст тус тус хүргүүлээ.

### **Сүхбаатар:**

**Төрийн удирдлагын чиглэлээр:** Covid-19 шинэ корона вирус дэлхийн улс орнуудад тархсантай холбогдуулж ард иргэдийнхээ эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалан ажиллаж байгаа сумын Онцгой комисст сумын ахмадын холбоо болон нийт ахмадууд 200 ширхэг маск, 146000 төгрөгний хандив, эмийн эргэлтийн сангаас 100 ширхэг маск, ариутгалын бодис тус тус хандивлалаа

Сумын Засаг даргын орлогч болон ЗДТГ-ын даргаар ахлуулсан ажлын хэсэг 3, 4-р багт тус тус ажиллаж малчидтай уулзан ярилцаж тэдний санал хүсэлтийг сонсохын зэрэгцээ төр засгаас хэрэгжүүлж байгаа бодлого, шийдвэр сум орон нутгийн цаг үеийн ажил үйлчилгээг малчин иргэдийнхээ хотонд хүргэн ажиллалаа. Үүнд:

2020 оны хаврын ээлжит цэрэг татлагын урьдчилсан үзлэгт цэргийн насны 74 иргэн орохоос 46 хамрагдаж 16 залуу дараачийн шатны үзлэгт орохоор боллоо.

**Эрүүл мэнд:** Шинэ Корона вирусийн халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор сумын Эрүүл мэндийн төвөөс албан байгууллага, аж ахуй нэгж, айл өрхүүдийн жорлон муу усны нүхэнд ариутгал халдваргүйжүүлэлт хийн мөн гэрийн нөхцөлд ариутгал халдваргүйжүүлэлтийг хэрхэн хийх талаархи зөвлөмж гарын авлагыг тараасан.

**Байгаль орчин:** 3 сарын 27-ноос 28-нд шилжих шөнө тус сумын 1-р баг, Эрдэнэцагаан сумын 6-р багийн зааг нутагт хууль бусаар ашигт малтмалын олборлолт хийж байсан үйлдлийг сум, аймгийн Цагдаагийн газартай хамтран таслан зогсоож тухайн газар нутгийг зургаан хүний бүрэлдэхүүнтэй баг хамгаалалтад аваад байсан ч 04 дүгээр сарын 02-ноос 03-нд шилжих шөнө улсын дугааргүй, 8-9 тээврийн хэрэгсэлтэй 20 гаруй иргэн тус газар руу хүч түрэн дайрч, мөн зөвшөөрөлгүйгээр ашигт малтмал олборлож эхэлсэн ба энэ талаар дахин дуудлага ирсний дагуу хоёр шуурхай бүлэг очин зогсоож, тухайн иргэдийг саатуулсан. Одоогоор аймгийн Цагдаагийн газарт 7 бүлгийн, 7 тээврийн хэрэгсэлтэй, 29 иргэнд эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж байна. Аймгийн Засаг даргын захирамжийн дагуу тус газарт 2 сум ээлжлэн хамгаалалтанд гарч ажиллаж байна.

2020 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр Дорнод аймгийн Матад сумын нутаг “Цар” гэдэг газраас гарсан хээрийн түймэр тус сумын 1-р багийн нутаг “Дөрвөлжин худгийн тал” гэх газарт орж ирсэн бөгөөд түймэр унтраах 7 хүний бүрэлдэхүүнтэй 1 дүгээр ээлжийг шуурхай томилон ажиллуулсан. Түймэрт 3200 га талбай болон 2 айлын өвөлжөө шатсан ба нийт 24,697,200 төгрөгийн зардал гарсан байна. Түймрийн эзэн холбогдогчийг тогтоож хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авахаар ажиллаж байна.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аяны хүрээнд нийтийг хамарсан ажил зохион байгуулж 10 иргэнээр нийтийн эзэмшлийн зам талбай, гуу жалганы хогыг цэвэрлүүлэх ажлыг зохион байгуулж байна.

### **Түвшинширээ:**

Сумын Онцгой комисс 04 дугаар сард нийт 2 удаа хуралдаж, цаг үеийн байдал болон сумын хэмжээнд хөл хорио тогтоох, сумын шуурхай штаб, хариуцлагатай жижүүр, түр ажиглах байрыг бэлтгэх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэж байна.

ЕБСургуулийн дотуур байрыг түр ажиглах байраар бэлгэж тохижуулах ажлыг зохион байгуулж бэлэн байдалд оруулсан.

ЗДТГ-аас багийн малчин өрхүүдээр явж суурь тойролт хийж хаваржилтын байдалтай танилцаж, төр захиргааны шийдвэрийг танилцуулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Малчин иргэдээс ОНХСангийн санал авах, гал түймрээс сэргийлэх, мөн



цар covid-19-ээс сэргийлэх анхан шатны зөвлөмж өгөх, төл бойжилттой танилцах зэрэг цаг үеийн мэдээ мэдээллийг хүргэж ажиллалаа.

2020 оны нэгдүгээр ээлжийн цэрэг татлагын ажлыг зохион байгуулж нийт 57 цэргийн насны залуучуудыг хамруулсан ба 19 цэрэг тэнцэж Сүхбаатар аймагт нэгдсэн үзлэгт орохоор болсон байна.

Хурдан морины уралдаанч хүүхдийн аюулгүй байдлыг хангах, зөвшөөрөлгүй уралдаалга зохион байгуулахыг хориглох тухай аймгийн Засаг даргын 2020 оны А/292 захирамжийг багийн Засаг дарга нар болон уяачдын холбоо, уяачдын галуудад танилцуулж ажиллалаа.

Хүүхэд, гэр бүлийн эрсдэлийг тодорхойлох, зураглал гаргах түргэвчилсэн үнэлгээний программд сумын нийт 540 өрхийн 0-17 насны бүх хүүхдийг хамруулаад байна. 5 багийн Засаг дарга болон ХХҮГ-ын мэргэжилтэн, Хүн ам зүйн мэргэжилтнүүд хамтран сумын эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа 107 хүүхдийн хэрэгцээ тодорхойлох үнэлгээг хийлээ. Уг судалгаанд амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой өрхийн хүүхэд-95, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд-12 хүүхэд хамрагдаад байна.

Амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой өрхийн хүүхдийн судалгаанд үндэслэн нэмэлт хоол хүнс тэжээлийн тусламж үзүүлэх ажлыг багийн Засаг дарга, байгууллагын дарга эрхлэгч нартай хамтран үзүүллээ. Нийт 5 өрхөд 4 байгууллага хүнсний болон түлээ нүүрсний туслалцаа үзүүлээд байна. 1 өрхөд 50 орчим мянган төгрөгийн хүнсний бараа, 4 шуудай нүүрс өгөөд байна.

**Байгаль орчин, Хөдөө аж ахуй:** Монгол Улсын Ерөнхий сайдын 2020 оны 01 тоот албан даалгавар, Аймгийн Засаг даргын А/190 дүгээр захирамж, сумын засаг даргын А/12 дугаар захирамжийн дагуу ЗДТГ, малын эмч, малчид, мал бүхий иргэдтэй хамтран хүүр сэг зэм устгах, ариутгал халдваргүйтгэлийн арга хэмжээг зохион байгууллаа.

Энэ ажлын хүрээнд малчид, мал бүхий иргэдэд ухуулга сурталчилгааг хүргэх зорилгоор уриалга гарган цахимаар сумын төвийн иргэдэд, ИТХ-ын дарга, Засаг дарга, Орлогч даргаар ахлуулсан ажлын хэсэг хөдөө малчдаар тойролт хийж сэг зэм болон өвөлжөө хаваржаагаа цэвэрлэж хогийн төвлөрсөн цэгт хаях, ариутгал халдваргүйтгэл хийх талаар зар хүргэж ажилласан.

Дэлхий нийтээр тархаж буй covid19 өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор сумын төвийн айл өрхийн нүхэн жорлон, хашаа хороо, гудамж талбайг ариутгаж халдваргүйтгэлээ. Нийт 110 өрхийн 22000 мкв талбайг ариутгасан байна.

ЗДТГ, БОТасаг, МЭТасаг, ХХҮХ-ын мэргэжилтэн, малын эмч, малчидтай хамтран халдварт өвчин болон байгалийн үзэгдлийн улмаас үхэж хорогдсон малын сэг зэмийг цуглуулах, булж устгах, айл өрхийн өвөлжөө, хаваржаа болон булаг шанд, худаг уст цэг орчмын хог хаягдал, үхсэн малын сэг зэмийг цэвэрлэх, ариутгах, халваргүйтгэх ажлыг зохион байгууллаа.

Аймгийн ХХҮГ-т “Сэг зэм, Хог хаягдал”, “Ногоон байгууламж” гэсэн 2 төсөл бичиж дэмжигдсэн ба өрхийн амжиргааны түвшин тогтоох судалгаанд хамрагдсан 10 өрх тус бүрээс 1 хүн хамруулж, цалинжуулан сумын төвийн хогийн цэг дээрх болон 5-км радиус тойрог дотор үхсэн мал, сэг зэм, хог хаягдлыг цуглуулж хогийн цэгт булж устгах ажлыг зохион байгуулж, устгалын цэгт 1600 бог, 114 бод, бүгд 1714 мал зөөж тээвэрлэн устгах ажлыг хийж гүйцэтгэсэн. Мөн Улаанбаатарын төв зам дагуу болон бусад 2 цэгт үхсэн мал, сэг зэм хог хаягдлыг устгах ажлыг зохион байгуулж, бод 56 бог 606 нийт 662 толгой малыг булж устгасан.

Мөн хашаа хороо ариутгах, нүхэн жорлон, муу усны нүх, гудамж талбай ариутгах ажлууд хийгдлээ. Хашаа 25 ш, 20000 мкв, нүхэн жорлон муу усны нүх 110 өрхийн 22000 мкв, орон сууц 9000 мкв, нийтийн эзэмшлийн талбай 9, 14850 мкв, тээврийн хэрэгсэл 30 ш, 300 мкв, авто зогсоол 500 мкв, худаг уст цэг 5, 2500 мкв, тэжээлийн агуулах 3, 300 мкв, түүхий эд хадгалах цэг 1 ш, 200 мкв, устгалын цэгийн талбай 400 мкв, бэлчээрийн талбай 5000 мкв, нийт 75050 мкв талбайг ариутгасан байна.

2019 онд хийгдсэн Шүлхийн вакцины идэвхжил, хөрсний бохирдол байгаа эсэхэд тандалт хийхээр аймгийн мал эмнэлгийн газраас ажлын хэсэг ирж ажиллав. 2 багийн 8 өрхөөс бог 80, бод 40, бүгд 120 толгой малаас цус авч шинжилгээнд хамруулав

Ургамал хамгаалал эрдэм шинжилгээний хүрээлэнгийн судлаач, багийн засаг дарга нартай хамтран сумын нутагт тархсан үлийн цагаан оготны судлалгааг гаргаж улсын

төсвийн хөрөнгө оруулалтаар 10000 га талбайд үлийн цагаан оготной тэмцэх ажлын гэрээг байгуулаад байна.

ХАА-н газарт 7 хоног бүрийн 3 дахь өдөр төлийн мэдээг хүргүүлж байна. Одоогийн байдлаар төл бойжилт 79 хувьтай байна.

Ноолуурын тоо хэмжээг бүртгэх, ажил хийгдэж байна. Одоогийн байдлаар 35тн ноолуур бүртгэгдсэн мэдээлэлтэй байна. Сумын ямааны тоогоор бүртгэвэл 41,381,200 тн ноолуурыг борлуулах бүртгэлд орохоор байна.

**Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт:** Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр зарлагдсан төсөл хөтөлбөрүүдийн талаар сумын групп болон иргэдэд утсаар болон дэлгүүрүүдэд зар тавин мэдээлэл өгч ажиллаа.

Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжих нийтийг хамарсан ажлыг зохион байгуулах арга хэмжээнд нийтийн эзэмшлийн зам талбайд бүтээн байгуулалт хийх, хог хаягдалгүй байлгах, байгаль орчиныг хамгаалах ажлыг хийж гүйцэтгэх "Сэг зэм" "Ногоон байгууламж" зэрэг сумын ЗДТГ-аас хийх ажлын төслийг ХХҮГ-т 2020 оны 04-р сарын 01-ны дотор хүргүүлсэн. Мөн Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2019 оны 01 тогтоолоор батлагдсан "Ажлын байрыг дэмжих хөтөлбөр"-ийн зохион байгуулалттай ажлыг дэмжих арга хэмжээнд сумын ажилгүй 5 иргэний бүлэг болгон байгуулан тухайн жилд хийх ажлын төлөвлөгөөг сумын Засаг даргаар батлуулан ХХҮГ-т хүргүүллээ.

**Эрүүл мэнд:** COVID-19-өөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд өндөржүүлсэн бэлэн байдалд орж эмч нар жижүүрлэн ажиллаж байна.

COVID-19 вирус гарч болзошгүй үндсэн дээр Эрүүл мэндийн төвөөс комбинзон маск, гутал зэрэг хамгаалах хэрэгсэлүүдийг өөрийн нөөц бололцоогоор авч бэлтгэсэн .

#### **Түмэнцогт:**

**Төрийн удирдлагын чиглэлээр:** Засаг даргын А/37 дугаар захирамжаар хаягийн мэдээлэл шалгах, засварлах, зэрэгцүүлсэн хаягийн мэдээлэл үүсгэх жагсаалт гаргах "Удирдамж"-ийг хэрэгжүүлэн ажиллах ажлын хэсгийг томилон ажиллуулж байна.

Сумын Засаг даргын Хязгаарлалтын дэглэм тогтоох тухай А/36 дугаар захирамж гарч Баянцагаан багийн нутагт Цусан халдварт өвчин оншлогдсон голомтоос гадагш эргэн тойронд 5 км радиустай нутаг дэвсгэрт 14 хоногийн хугацаатай хязгаарлалтын дэглэм тогтоосон.

Covid-19 шинэ төрлийн вирустэй холбогдуулан ААНэгж, байгууллага, ТББ, иргэн хамтран Эрүүл мэндийн байгууллагаас гаргасан зөвлөмж, чиглэл, зааврийг тухай бүр сурталчилан, онлайн мэдээ, мэдээллүүдийг түгээж нийт 4021 ширхэг гарын авлага тарааж, Цахимаар 148 төрлийн мэдээлэл хийсэн.

**Байгаль орчин:** Нийтийн эдэлбэр газрыг сумын Засаг даргын А/34 дүгээр захирамжаар хуваарилж 8 талбайд хариуцсан байгууллага, албан хаагчид их цэвэрлэгээ хийсэн ба 14тн хог хаягдал цуглуулж, тээвэрлэж нэгдсэн хогийн цэгт зөөвөрлөж хаялаа.

Сумын төвийн болон зам дагуу үхсэн малын сэг зэм - бод 348, бог -471 цуглуулж ачиж тээвэрлэн нэгдсэн хогийн цэгт хаясан ба ариутгал халдваргүйтгэлийг хийсэн.

**Мал эмнэлэг:** сумын Засаг даргын А/27 дугаар захирамжийн дагуу Ариутгал халдваргүйтгэл зохион байгуулах ажлын хэсэг томилогдож:

- ✓ Гэр хорооллын айл өрхийн муу усны нүх, жорлон 270 өрхийн 3600 м<sup>2</sup>
- ✓ Нийтийн эзэмшлийн зам талбай 25 хэсэг 2700 м<sup>2</sup>
- ✓ Тээврийн хэрэгсэл 36 ширхэг 740 м<sup>2</sup>
- ✓ Авто зогсоол 950 м<sup>2</sup>
- ✓ Орон сууц 2765 м<sup>2</sup>
- ✓ Малын хашаа, хороо, мал амьтны тоног хэрэгсэл 188 ширхэг 76000 м<sup>2</sup>
- ✓ Худаг, уст цэг 12 ширхэг 700 м<sup>2</sup>
- ✓ Зоорь, агуулах 18 ширхэг 1699 м<sup>2</sup>
- ✓ Тэжээлийн агуулах 1 ширхэг 128 м<sup>2</sup>
- ✓ Түүхий эд бүтээгдэхүүн хадгалах цэг 1 ширхэг 96 м<sup>2</sup>
- ✓ Халдваргүйжүүлсэн бүс, цэг
  - голомтын бүсийн талбай 712 м<sup>2</sup>
  - устгалын цэгийн талбай 1512 м<sup>2</sup>
- ✓ Сэг зэм - бод 348, бог-471, нохой 78

✓ Бэлчээрийн талбай 41500 м<sup>2</sup> нийт 133102 м<sup>2</sup> талбайг супер килл, Ni-cop, экоцид 40,5 кг бодис зарцуулж ариутгал халдваргүйтгэлийг хийж гүйцэтгэсэн байна.

**Хүнс, хөдөө аж ахуй:** Коронавирустай холбоотой гарсан тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх зорилгоор дээрээс гарсан шийдвэрийн дагуу суманд үйл ажиллагаа явуулж байгаа 2 караоке, барны үйл ажиллагааг бүрэн зогсоосон бөгөөд хүнсний худалдаанаас бусад тусгай зөвшөөрөлтэй болон нийтийн хоол үйлдвэрлэлийн аж ахуйн нэгжийн ажиллах цагийн хуваарийг 08.00 цагаас 20.00 болгон тогтоосонтой холбоотой цагдаагийн байгууллага хяналт тавин ажиллаж байна. Мөн ариутгал халдваргүйжүүлэлтийг 2 цаг тутамд хийх, амны хаалтыг тогтмол хэрэглэх, амны хаалтгүй иргэдэд үйлчлэхгүй байх шаардлагатай бол камерийн бичлэгийг ухрааж үзэн хяналт тавин ажиллаж байхыг анхаарууллаа.

МХГазрын зөвлөмжийн дагуу 2 м зай барь болон сумын шуурхай штабын албан тоотыг төсөвт 5 байгууллага, 3 ШТС, 2 банк, 16 ААНэгж дэлгүүрүүдэд танилцуулж хүргүүлэн ажилласан. Хоол үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа "Тамир" ресторанд удирдамжийн дагуу хяналт шалгалтыг хийж заавар зөвлөгөө өгч ажилласан.

Том малын зүй бус хорогдол болон мал төллөлтийн мэдээг 7 хоног тутамд багийн дарга нараар гаргуулан нэгтгэн аймгийн ХХААГазарт хүргүүлэн ажиллаж байна.

Том малын зүй бус хорогдол 04.24-ний байдлаар 3169, төл бойжилт 50-60%-тай байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлагыг дэмжин сумын иргэдээс 108 хонь хандивласаныг батламжилж, малчдад Батламж гардууллаа.

Монгол Улсын Засгийн газраас "Ноолуурын салбарт авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээ"-ний тухай 101 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор 291 малчин, мал бүхий өрхийн 42500 мян. толгой ямааны 13,6 тн ноолуур бэлтгэсэн судалгааг гаргаад байна.

**Хөдөлмөр, халамж :** Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгогдох төсөл хөтөлбөр зарлагдсантай холбоотой ХХҮГазарт 13 төсөл хүргүүлсэн.

**Боловсрол:** Хими, Англи хэл, Монгол хэл, Биологийн хичээлээр ЭЕШ өгөх сурагчдаас Онлайн шалгалтыг БСУГ-аас авч сурагчид 100% хамрагдлаа.

Сумын Хүүхэд хамгааллын хамтарсан баг хуваарь гарган өдөр бүр хяналтын жижүүр ажиллуулж байна.

Сумын хэмжээнд "Соёлч байдлыг эрхэмлэе, элдэв эрсдэлээс өөрийгөө хамгаалъя" сарын аяныг зарлаж олон нийтэд хяналт тавьж, зөвлөгөө, зөвлөмжийг хүргэн ажиллаж байна.

Теле хичээлтэй холбоотой сурагчдын ойлгоогүй үлдсэн агуулгаар багш нар цахим хичээл бэлтгэж байна. 4.9-нөөс хойш 4-н хичээлийг бэлтгэж хүргэлээ.

Цахим хичээл үзэж буй байдлын судалгааг дэлгэрэнгүйгээр АУБ нараас 7 хоногт 2 удаа авч БСУГ-т мэдээлж байна. Сүүлийн 7 хоногийн байдлаар 1-12-р ангийн 23 бүлгийн 521 сурагчаас 414 буюу 79,4% нь үзсэн байна. Үүнээс боловсролын түвшингээр авч үзвэл: Бага анги-83,4%, Дунд анги-71,3%, Ахлах анги-81% байна.

Засгийн газрын 139 дүгээр тогтоол батлагдаж, бүх шатны боловсролын байгууллага, сургалтын төвийн танхимын сургалтын үйл ажиллагааг 2020-09-01-ний өдрийг хүртэл зогсоосонтой холбогдуулан БСШУС-ын сайдын 2020 оны "Цэцэрлэг, ЕБС-ийн хичээл, сургалтын үйл ажиллагаанд зохицуулалт хийх тухай А/194 дүгээр тушаал гарсантай холбогдуулан сургалтын үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах зорилгоох үлдсэн хугацааны бүх хичээлийн агуулгыг Теле болон цахим хэлбэрээр явуулах шийдвар гарсны дагуу теле хичээлийг хуваарийн дагуу хүүхдүүддээ үзүүлэх идэвхийг сайжруулж ажиллах тал дээр багш нартаа үүрэг даалгавар өгч, мөн теле хичээлийн агуулгатай уялдаа холбоотой бататгал дасгал даалгаврыг бэлтгэн цаасан хэлбэрээр тарааж ажиллах, цэцэрлэгийн болон бүлгүүд дотоод группээрээ дамжуулан эцэг эх асран хамгаалагчидтай холбогдон боловсрол, үүсч буй нөхцөл байдалтай холбоотой эрүүл мэндийн зөвлөгөө, зөвлөмжийг цаг тутам оруулж мэдээлэл хийж судалгаа авч хамтарч ажиллах, мөн дээрх тушаалтай холбогдуулан цэцэрлэгийн хүүхдийн хичээлийн жилд хэрэглээгүй үлдсэн ариун цэвэр, хичээлийн хэрэгслийг эцэг эхэд буцаалт хийх ажлыг 100 хувь хийж гүйцэтгэн ажилласан.

- БСУГ болон холбогдох байгууллагуудтай байнгын уялдаа холбоотой ажиллаж бусад байгууллагаас авч буй мэдээ судалгааг цаг тухайд нь үнэн зөв гарган мэдээллэж хамтран ажиллаж байгаа.

- Хувилбарт сургалтанд хамрагдаж буй 8 хүүхдийн гэрээр нь эргэлт хийж ном тоглоомын багцыг нь сольж, цаасан дасгал даалгавар болон мемори картанд сонсдог үлгэр дуу суулган өгч нөхцөл байдалтай танилцаж ирсэн.

- Мөн 2020-05-01-ыг хүртэл зарлагдсан “амны хаалтаа зүүцгээе” аянд нэгдэж олон нийтийн цахим хуудас болон байгууллагын дотоод групп, бүлгүүдийн группэр амны хаалтаа зүүцгээе зурагт давалгааг уриалж, будын давалгаанд нэгдэн 156 хүнийг давалгаандаа нэгтгэж, гэр бүл, хамт олноороо хайртай хүмүүсээ хамгаалаа уриалгад нэгтгэсэн.

**Соёл:** Байгууллагын цахим хаягаар “Дарьганга тойрон бүжиг”-ийн бичлэгт бүтээлийг ардын авьяастанууд, дугуйлангийн сурагчдын төлөөллийг оролцуулан хийж иргэдэд хүргэлээ. Нийт 231 иргэн хандаж бичлэгийг үзэж сонирхсон байна.

Хөдөлгөөний дутагдалаас сэргийлэх зорилгоор иргэдэд гэрийн нөхцөлд дагаж гүйцэтгэх боломжтой байдлаар бэлтгэн “16 тоот” бүжгийн бичлэгийг цахим хаягаар иргэдэд хүргэлээ. Уг бичлэгийг 2639 иргэн хандаж үзсэн байна.

Түмэнцогт Соёлын төв facebook группээр заавал сурах 16 бүжиг буюу нийтийн бүжгийн үүсэл хөгжлийн талаарх мэдээллийг цувралаар иргэдэд мэдээлж нийт 139 иргэн мэдээлэл авсан байна.

Инээдмийн баярын өдрийг тохиолдуулан Соёлын группын Соёлтой залуусынхаа дунд зохион байгуулсан "Соёлтой селфи" уралдааныг зохион байгууллаа. Уг уралдаанд нийт 70 оролцогч оролцсон.

Хорио цээрийн дэглэмийн үед иргэдэд өөрийн байгууллагын цахим хаягаар Дасгал 9 удаагийн цуврал хичээл хүргэж 73 иргэд мэдээллийг авсан бол, хөдөлгөөн-Эрүүл мэндийн ач холбогдол, хөдөлгөөний дутагдалын талаарх 8 удаагийн зөвлөмж хүргэж 63 иргэн хандаж мэдээлэл авсан байна.

Номын сангийн өдөр тутмын үйл ажиллагаа хэвийн явагдаж, энэ сард гэрээр ном олгох үйлчилгээгээр нийт 57 уншигчид 63 ш ном олгогдож үүнээс насанд хүрэгч 32, хүүхэд 25 олгож үйлчиллээ. Мөн Соёлын төвийн нүүр хуудсаар дамжуулан 22 цахим өгүүллэг байршуулж давхардсан тоогоор нийт 150 гаруй иргэдийн хандалттай байна.

Хүүхдийн номын өдрийг тохиолдуулан Данийн зохиолч Х.К. Андерсоны намтар уран бүтээлийг цахимаар уншигчдад хүргэлээ.

Иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор Монгол хүн бүрийн Заавал мэддэг байх 10 шүлгийг зохиолчийн намтартай хамт цахимд байршууллаа.

Утгын чимэг-2020 яруу найргийн уралдааныг Заавал мэддэг байх 10 шүлгээр зохион байгуулж, ирсэн видео бичлэгүүдийг цахимд байршуулж байна.

Түмэнцогт сумын уугуул зохиолч яруу найрагч Чүлтэмжамцын Даваасүрэнгийн “ТА АМАРХАН САЙН БАЙНА УУ” шүлгийн түүврээс уран уншигч Б.Долгормаатай хамтран видео бичлэг хийн цахимд байршуулж байна

Дэлхийн номын өдрийг тохиолдуулан Сүхбаатар аймгийн уран бүтээлчийн бүтээлийг цахимаар иргэдэд сурталчлан, зохиолч Ч.Наранцэцэгийн “Гүйгүүл бэр” хошин өгүүллэгийг подкат хэлбэрээр уншигчдад хүргэж байна.

Угийн бичгийн цахим хичээлийг цувралаар зохин байгуулж Түмэнцогт Соёлын төв нүүр хуудсанд байршуулан иргэдэд мэдээлэл хүргэж байна.

Шинэ төрлийн короновирус буюу Ковид-19 цар тахлын хорио цээрийн дэглэмийн үед Соёлын төвийн нийт ажилчид иргэдэд байгууллагын цахим хаягаар Соёл урлаг-Үндэсний дархлаа, Инээд хайр, Зөв хандлага, Эерэг байдал дархлаа дэмжинэ, К.-ний эсрэг бүжиглээрэй, Эрүүл мэнд-Эрхэм баян зэрэг уриалгыг хүргэлээ.

Соёлын байгууллагын талаар болон соёлын төвд зохион явагдаж буй арга хэмжээ, хэрэгжсэн төсөл хөтөлбөрүүд зэрэг агууламжтай мэдээллийг Ардчилал таймс сонинд эрхлэгч Х.Эрдэнэдэлгэр ярилцлага өгч, иргэдэд хүргэлээ.

**Эрүүл мэнд:** Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбоотой 24 цагийн хариуцлагатай жижүүр томилогдон өдөр бүр эрүүл мэндийн газарт мэдээгээ өгч байна. Зайлшгүй шаардлагатай төхөөрөмж, хувийн хамгаалах хэрэгслийн нөөц бүрдүүлж байна

03 сарын 30- 4 сарын 4-ний өдрүүдэд сумын төвийн 4 дүгээр багийн 32 айлаар явж гэрийн эргэлт хийж 74 иргэнд урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулан, Covid-19 талаарх мэдээлэл өгч, 5 төрлийн 160 ширхэг гарын авлага тараалаа.

ЭМТ-ийн эмч ажилчид иргэдэд COVID-19 халдвараас урьдчилан сэргийлэх зөвлөмж, маск зүүх уриалгыг хүргэж ажиллаж байна. 80 хүнд 150 ширхэг материал тараасан. Улсын онцгой комиссын 2020 оны 04 сарын 11 өдрийн 09 тоот шийдвэрийн дагуу орон нутагтаа аяны хүрээнд “БИ МАСКАА ЗҮҮЦГЭЭЕ аянд нэгдлээ” challenge эхлүүлж 3, 3 хүн дуудсанаар 70 гаруй хүн аянд нэгдэж 10000 орчим хандалт авлаа.

### **Уулбаян:**

Төсөв санхүү: Орон нутгийн орлого төлөвлөгөөгөөр 13537,6 мянган төгрөг орохоос 11639,4 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй орлогын төлөвлөгөө 86,0 хувийн биелэлттэй байна.

2020 оны 4-р сарын байдлаар аймгийн санхүүгийн дэмжлэг 149000.0 мянган төгрөг ирэхээс 149000.0 мянган төгрөг ирж 100 хувийн гүйцэтгэлтэй.

**Худалдан авах ажиллагаа:**Нийтийн эзэмшлийн орон сууцны дээврийн засварын тендерийг цахимаар зарлаж 20-ны өдөр тендерийг нээж ЛХАТОНОМ ХХК шалгарсан. Мөн хогны машин худалдан авах тендерийг 4-сарын 13 ны өдөр зарлаж 23-ны өдөр тендерийг нээхэд 7 компани материалаа ирүүлээд байна.

2020 оны ОНХСангийн санал асуулгыг уламжлалт аргаар болон цахимаар авч байна. 4 сарын байдлаар 100 орчим иргэн цахимаар саналаа өгөөд байна.

Тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд 3908500 төгрөгийн хандив орсон ба Covid-19 цах тахлаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд сумын ЭМТ-д 3600000 төгрөгөөр уураар ариутгагч Автоклабыг Ашид Буян ХХК-с худалдаж авч шилжүүллээ.

**Хөдөө аж ахуй:**Мал эмнэлгийн нэгдсэн программд 2019 оны төлөвлөгөөттарилгыг хувийн хэвшлийн малын эмч нараас авч нэгтгэн орууллаа.

Бух , бог малын хээлтүүлэгчийн тоогоор ээмэгний захиалга бух 113, хуц 1035, ухна 514 бүгд1662 хээлтүүлэгчээс бух 8, хуц 50, ухна 24 нийт 82 ээмэгний захиалга өгөөд байна.

**Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт:** “Хайрын сар” аяны хүрээнд “ХАМГААЛЪЯ- ХАЛАМЖЛАЯ” үйл ажиллагаанд хамрагдсан зорилтот 5 өрхөд аймгийн ГБХЗХГазраас ирсэн зүйлүүдийг хүргэж өглөө.

Цахилгааны болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор олон хүүхэдтэй зорилтот бүлгийн өрхүүдээр явж цахилгааны аюулгүй байдлыг шалган, заавар зөвлөмж өгч ажиллалаа.

Сайн дурын даатгалд 98 даатгуулагчидтай шинээр гэрээ байгуулан 14008.6 мян төгрөгийн шимтгэл, Эрүүл мэндийн даатгалд 125 даатгуулагчийг даатгаж 5231.9 мян төгрөгийн шимтгэл төвлөрүүлсэн.

Ажилласан жил нөхөн төлүүлэхээр 9 хүний материалыг хүлээн авч НДХэлтэсээр шалгуулан 7256,0мян төгрөгийг шимтгэлийг төвлөрүүлэн аваад байна.

**Боловсрол:** Хүүхдийн цэцэрлэгийн багш нар гэрээр бүх бүлгийн “Теле хичээл”-ийг үзэж тэмдэглэл хөтлөн ажиллаж байгаа бөгөөд теле хичээлийн хамрагдалт 80,6% -тай.

Багш ажилчид хамтран 32 ном, тоглоомын багцыг засан сайжруулж шинэчлэлээ.

ЕБС, багийн Засаг дарга нартай хамтран хөдөөгийн 4-н багийн хүүхдүүдийг эргэж, 49 хүүхдэд ном, тоглоом, гарын авлага, ковид-19 өвчнөөс урьдчилан сэргийлэх зөвлөмж өглөө.

“Гэр бүлийн орчинд сургуульд бэлтгэх хөтөлбөр”-ийн хүрээнд “Ном тоглоомын багц ашиглах заавар” “Гэрийн анхны тусламж”-н иж бүрдэлийг хэрхэн бүрдүүлэх талаарх зөвлөмжийг бэлтгэн цахим хуудсанд байршууллаа.

ЕБС-ийн багш нартай хамтран хуваарь гарган гадуур тоглоомын талбай олон нийтийн газар маскгүй явж байгаа хүмүүст шаардлага тавьж ажиллаж байна. Мөн иргэдэд айл хэсэхгүй байх зөвлөмжийг утсаар холбогдож өгсөн ба нийт хүүхдийн 87,5 хувьд нь уг зөвлөмжийг хүргэж ажиллалаа.

Соёл: Нийтийн номын сан групп хаягаар “Цахим уншлагад нэгдэцгээе” аян зохион байгуулж зохиол бүтээл байршуулж иргэдэд цахим үйлчилгээ үзүүлж байна. Мөн Уулбаян Соёлын төв цахим хаягт “Нийтийн бүжиг” бусад мэдээлэл сурталчилгааг байршуулаад байна.

Эрүүл мэнд: Урьдчилан сэргийлэх үзлэг-215, идэвхтэй хяналт-57, дуудлагаар гэрийн үзлэг-62, гэрийн идэвхтэй үзлэг-72, алсын дуудлага-48, жинлэсэн хүүхдийн тоо-21, артерийн гипертензи-117, хөх-145, эсийн шинжилгээнд-45 хамрагдаж нийт 1015 үзлэг хийж, эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлсэн байна.

**Хууль, эрх зүйн чиглэлээр:** “Ковид-19” вирусийн тархалттай холбоотой мэдээлэл зөвлөмжийг 7 хоног бүр иргэдэд хүргэж, мэдээг 7 хоног бүр ГБХЗХГ-т хүргүүлж байна.

“Төрийн үйлчилгээг Малчны хотонд” уриан дор Тамгын газраас баг томилон ажиллуулж малчдаас ОНХС-аар хийгдэх ажлуудын санал асуулга авах, “Хурдан морины үсэргээ, сунгаа, тар, бооцоот уралдаан зэргийг хориглох тухай” МУ-н Засгийн газрын тогтоол, Аймаг, сумын Засаг даргын захирамжийг уяачдад танилцуулах, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, халамж, нийгмийн даатгалын чиглэлээр мэдээлэл сурталчилгааны хийх зэрэг ажлуудыг зохион байгуулж ажиллалаа.

#### **Халзан:**

**Сумын ИТХ:** Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн ээлжит хуралдааныг хуралдуулж, Алдарт эхийн одонд тодорхойлогдож буй эхчүүдийн материалыг хүргүүлэх, Сонгуулийн зар сурталчилгааны самбар, зурагт хуудас байршуулах байршил тогтоох тухай, сумын сонгуулийн хороонд ажиллах албан хаагчдын санал хүргүүлэх тухай зэрэг асуудлыг хэлэлцэн батллаа.

**Засаг даргын Тамгын газар:** Засгын газрын 149-р тогтоолын дагуу үйлчилгээний нэгдсэн төвд ажиллах, цахимаар үйлчилгээ үзүүлэх операторын сургалтад суух, ажиллах бэлтгэлийг ханган ажиллаж байна.

04 сарын цаг үеийн холбогдолтой мэдээг бэлтгэн орон нутгийн “Сүхбаатарын өнгө” сонинд хэвлүүллээ.

**Төсөв санхүү:** Энэ сард аймгаас авах санхүүгийн дэмжлэгээр 47200,0 мянган төг авч, сумын татварын орлогоор 1162,6 мянган төгрөг орсон.

ОНХС-ийн орлогын шилжүүлгээр 3831,0 мян/төг санхүүжилт ирсэн байна. Энэ сард 1-р багийн их засварын ажлаар УБ хотын “И.Пи.Эс” ХХК тендерт шалгарч 19898,5 мянган төгрөгөөр ажил гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулсан байна.

**ЕБС:** Теле хичээлийн ирцийг 7 хоног бүр анги бүлгээр нь авч бага, суурь боловсролын түвшинд нэгтгэн БСУГ-т өгөхөөс гадна ирцэд анализ хийж, үр дүнг графикаар харуулан, зөвлөмж, зөвлөгөөг тогтмол өгч ажиллаж байна. Үүний үр дүнд багш нарын идэвх оролцоо сайжирч сурагчидтайгаа эргэх холбоотой ажиллаж байна.

Теле хичээлийн хуваарийг сум, сургуулийн хаяг, дотоод группээр дамжуулан өгөхөөс ЭМЯ-наас өгч буй зөвлөмжөөр боршюр бэлтгэн хүргүүлсэн. Теле хичээлээ E content-оор нөхөж үзэх зөвлөмжийг өгөхөөс гадна, ангийн групп руу түгээж дахин үзэх боломжоор ханган ажиллаж байна. 300 гаруй эцэг эх, иргэдэд боршюр, 190 сурагчид теле хичээлийн хуваарь хүргэсэн байна.

1 болон 5-р ангийн багш нар анги, бүлгийн группээр дамжуулан эцэг эх, сурагчдаа идэвхжүүлэх, үр дүнг нь дээшлүүлэх зорилгоор цахимаар уралдаан зарлаж, дүгнэсэн байна. Үүний үр дүнд теле хичээл үзэх сурагчдын тоо нэмэгдэж, тэмдэглэлээ багшдаа илгээн эргэх холбоотой ажилладаг болсон. 2 багш, 25 эцэг эх, 38 сурагч хамрагдсан.

Zoom программ ашиглан цахим сургалт, онлайн хурлыг зохион байгуулж, BANDIKAM, POWTOON, point, программыг ашиглан цахим хичээл, зөвлөмж, цахим мэдээлэл, google docs, google drive апп ашиглан сорил, судалгаа боловсруулан ажиллаж байна. Теле хичээлээс олж авсан мэдлэг чадварыг нь бататгах зорилгоор цахим хичээл-21, цахим сорил- 25 ыг боловсруулан сурагчдаараа хийлгэж, эргэх холбоотой ажилласан.

“Шоголтой ном” явуулын номын санг ажиллуулж байна. Сурагчид номыг шимтэн уншиж, уншсан номын тэмдэглэл хөтлөх, үйл явдлыг нь зургаар илэрхийлэх, бүтээл хийх зэргээр сурагчдын чөлөөт цагийг зөв өнгөрүүлэх, номонд дуртай болгох зэрэг үр дүнтэй ажлыг зохион байгуулсан.

**Цэцэрлэг:** Багш ажилчид 160ш амны хаалт оёж, хуримтлалын мөнгөнөөсөө 100000₮ хамт сумын ЭМТ-д, Боловсролын байгууллагын багш ажилчид, ахмад багш нарын холбоо хамтран хандивын аян өрнүүлж аймгийн онцгой комисст багш ажилчид 80000₮, сумын онцгой комисст 150000₮ тус тус хандивласан байна.

**ЭМТ:** 2020 оны 04 сард Эрүүл мэндийн даатгалын сангаас 43 иргэнд 1354730 төгрөгний тусламж үйлчилгээг үзүүлсэн.

Маскаа зүүх аяны хүрээнд 200 ш маск оёж зорилтод бүлгийн иргэдэд тарааж өгөв. Мөн гэрийн эргэлтээр өндөр настан, 0-5 насны хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамруулан илрүүлэг үзлэгийг эрчимжүүлж ажиллаж байна.

**Мал эмнэлэг:** Аймгийн засаг даргын А/190, Сумын засаг даргын А/29 дүгээр захирамжийн дагуу орчны цэвэрлэгээ, ариутгал халдваргүйтгэлийн ажлыг сумын хэмжээнд зохион байгуулж, 127 жорлон муу усны нүх 3032м<sup>2</sup>, Нийтийн эзэмшлийн талбай 9 2300м<sup>2</sup>, Авто зогсоол 11 1100м<sup>2</sup>, тээврийн хэрэгсэл 6 60м, түүхий эд бүтээглэхүүний зоорь агуулах 1 400м<sup>2</sup>, малын хашаа хороо 55, малын тоног хэрэгсэл 22, өтөг бууц 3170м<sup>2</sup> нийт 17670м<sup>2</sup> талбайд ариутгал халдваргүйтгэл хийсэн байна. Мөн 109 хүүр сэгийг устгаж, 252м<sup>2</sup> талбайд ариутгал халдваргүйтгэл хийсэн. Худаг уст 4 1200м<sup>2</sup>, бэлчээрийн талбай 4000м<sup>2</sup> Нийт сумын хэмжээнд 33184м<sup>2</sup> талбайд ариутгал халдваргүйтгэл хийгээд байна.

**Сум хөгжүүлэх сан:** Нийт 18 зээлдэгч байгаагаас 2020 оны 03 сарын зээлийн эргэн төлөлтийн орлого 4 хүнээс 1,207,000 мянган төгрөгний орлогыг сум хөгжүүлэх сангийн дансанд төвлөрүүлсэн байна. 18 зээлдэгч нартай утсаар ярин эргэн төлөлтөнд төлөх тал дээр анхаарч ажиллаж байна.

**Байгаль орчин:** Нийтийн эзэмшлийн гудамж талбайн ахуйн хог хаягдлыг цэвэрлэх ажлыг зохион байгуулахад ЗДТГ, ЭМТ, ЕБС, Хүүхдийн цэцэрлэг, Соёлын төвийн нийт 83 ажилчин албан хаагчид оролцож 10 тн хогийг сумын төвийн нэгдсэн хогийн цэгт төвлөрүүлэв.

Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх санамж, сэрэмжлүүлэг 2, видео хичээл 2-ийг “Шинэ халзан цахим группэд байршуулсан.

#### **Эрдэнэцагаан:**

Сумын засаг даргын 68 дугаар захирамжаар Хууль бус ашигт малтмалын олборлолт явуулж байж болзошгүй гэсэн мэдээллийн дагуу 6-р багийн нутаг дэвсгэрийн Төмстэй Сэрвээ гэдэг газрыг байнгын хамгаалалтанд авч ажиллаж байна.

Ноолуур авах үеэр хүн амын хөдөлгөөн ихссэнтэй холбогдуулан Сумын Онцгой комисс, ГТУА-47-р анги, Цагдаагийн тасагтай хамтран иргэдийн орж гарах хөдөлгөөн машины дараалалд зохицуулалт хийж, Эрүүл мэндийн төвөөс иргэд гараа ариутгах, амны хаалт зүүх зэрэг хувийн ариун цэврийг хэрхэн сахиж байгаад хяналт тавьж, 3 төрлийн ширхэг зөвлөмж тараан ажиллалаа.

2021 онд ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлыг нийт өрхийн 50 хувиас санал асуулгаар авч эрэмбэлсэн.

ЗДТГ болон бусад төсвийн байгууллын удирдлагууд хамтран 39 хэсэг болж ажиллан, сумын төвийн эзэнтэй байсан нийт 528 айл өрхөөр явж галын аюулгүй байдал, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, хог хаягдлын тухай хуулийг сурталчилж урьдчилан сэргийлэх зөвөлгөө өгч гарын авлага материал тараалаа.

Монгол улсын Ерөнхийлөгчийн уриалгыг иргэд, малчид дэмжин 8 багаас нийт 200 хонь хандивлахаар шийдвэрлэснийг батламжилж аймгийн Засаг даргад батламжаа гардуулж өглөө.

2020 оны ээлжит цэрэг татлагад сумын хэмжээнд 68 цэрэг урьдчилсан үзлэгт орж 28 залуу цэргийн жинхэнэ албанд тэнцээд байна.

ХХААХҮЯ-наас “Халдварт өвчний хорио цээрийн дэглэм” нийгэм эдийн засагт хэрхэн нөлөөлж буйг судлах эдийн засаг нийгмийн судалгаанд 1.2-р багийн 40 өрх тус тус хамрагдсан.

**Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр:** Эрдэнэцагаан сумын Гал түймэр унтраах 47-р ангийн 23 албан хаагчдад Хамгаалах хувцас өмсөх, тайлах сургалтыг зохион байгууллаа.

Коронавирүсээс урьдчилан сэргийлэх айл өрхөд өгөх зөвлөмж, давсны хэрэглээг багасгах талаарх зөвлөмжүүдийг эмч, эмнэлгийн ажилчид олшруулан хуваарилан авч нийт 200 айлын хашааны хаалган дээр наасан.

ЭМТ-ийн дарга, НЭМА, ахлах сувилагч нар 16 айлын 28 хүнд 5 төрлийн /гал түймрээс урьдчилан сэргийлэх, томуу томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх, коронавирүсээс урьдчилан сэргийлэх, ариутгал, халдваргүйтгэл хийх зааварчилгаа / 112 зөвлөмж, гарын авлага 56 маскын хамт өгч, 5 өндөр настан, 3 хүүхдэд урьдчилан сэргийлэх үзлэг хийн ажиллалаа.



Албан байгууллага, хүнсний дэлгүүр, үйлчилгээний газруудад тус тус Ковид-19 сэрхийлэх иргэдэд өгөх зөвлөмж, Эмнэлгийн байгууллагаар үйлчлүүлэхгүй байх, 2 метр зай барих уриалга, гар угаах дараалал, Сүрьеэ өвчний талаар зэрэг 5 төрлийн 75 ширхэг зөвлөмжийг тараасан.

**Боловсрол:** теле хичээлийг 1359 сурагчаас сумын төвд-625 сурагч буюу 45.9%, хөдөө-672 сурагч буюу 49.2%, бусад аймаг, хотод 62 сурагч буюу 4.7% нь үзэж байна.

12-р ангийн Онлайн орчинд суралцах боломжтой 41 сурагч буюу 73.2 хувь нь сорилд тогтмол хамрагдаж байна.

Багш бүр bandicam, zoom, power point, rekor, google from, powtoon гэх мэт программыг ашиглан 152 цахим хичээл боловсруулан сургуулийн болон ангиудын цахим хуудсанд байршуулсан байна. Мөн АУБ нар болон мэргэжлийн багш нар нэмэлтээр 815 ш даалгаврын сан бүрдүүлэн ажилласан. Цаг үеийн мэдээллийг цахимаар 285 мэдээллийг нээлттэй 4 групп болон 42 ангийн дотоод групп, Элсэлтийн ерөнхий шалгалтанд бэлтгэх 9 группээр мэдээллийг тухай бүр нь байршуулан хүргэн ажиллаж байна.

3-12-р ангийн сурагчдын дунд " Ном миний хобби" цахимаар зохион байгуулсан уралдаанд 60 сурагчийн 150 тэмдэглэл ирснийг ангилал тус бүрт эхний 5-н байрыг шалгарууллаа. 1-2-р ангийн сурагчид уншсан үлгэрийнхээ тухай видео бичлэгээ ирүүлж оролцсон.

Боловсролын үнэлгээний төвийн мэргэжилтнүүдээс зохион байгуулсан Цахим сорилд 21 сурагч 52 хичээлээр хамрагдсан.

Миний гэр бүл-миний аз жаргал гар зургийн уралдаанд 1-5-р ангийн сурагчдын 86 бүтээл ирснээс эхний 4 байрыг шалгарууллаа. Мөн цахимаар эцэг эхчүүд дунд зохион байгуулсан " Хүүхдийн хүмүүжилд- миний оролцоо " зохион бичлэгийн уралдаанд 15 эцэг эх оролцсоноос эхний 2 байрыг шалгаруулсан.

Хорио цээрийн дэглэмийн үед 11 багш 1,5 ба 10 жилийн үндсэн сургалтанд, Дорнод аймгийн магистр-12, МУБИС-н магистрт-7 багш цахимаар сургалтанд хамрагдаж мэдлэг боловсролоо дээшлүүлэн ажиллаж байна.

**Сургуулийн өмнөх боловсрол:** Сургуульд бэлтгэх хөтөлбөрийн хүрээнд хөдөө орон нутгийн хүүхдүүдийг гэрээр нь эргэж номын багцын гүйцэтгэлийг шалгаж "Гэр аюулгүй" орчин судалгаа" болон ахуйн ослоос урьдчилан сэргийлэх зөвлөмжийг өгч ажиллаа.

Багш нар бүлгийн хүүхдүүдийнхээ гэрийн даалгаврыг 4 төрлөөр хийж 130 эцэг эхчүүдэд хэвлэн өгсөн.

Цахимаар болон цаасан хэлбэрээр авах, "Дуучин гэр бүл", "Даам сурах аян", "Миний гэр бүл сэдэвт зураг" "Цэгээр наадъя" зэрэг 6 төрлийн уралдааныг зарлаад байна.

"COVID-19" халдвараас сэргийлж масктай аянд нэгдэж бүр ажилчид 3 ээлжийн маск оёлоо. 50ш маск оёж хилийн цэргийн ангид хандивласан.

**Соёл:** Цахим хаягаар "**МИНИЙ МЭДЭХ БҮЖГИЙН БОЛОВСРОЛ**" сэдэвт гар зургийн уралдааныг зарлаад байна.

**Эрүүл мэнд:** Сувилахуйн тусламж үйлчилгээг давхардсан тоогоор 2221 хүнд үзүүлсэн байна. Үүнээс: Эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн 53, өдрийн эмчилгээнд 11 хүн, амбулаторын тусламж үйлчилгээ 160, гэрийн эргэлт 26 хүнд тус тус үзүүлсэн. Анхан шатны тусламж үйлчилгээнд 1525 хүнд үзлэг хийснээс ,720 урьдчилан сэргийлэх үзлэг хийж, 53 хүнийг хэвтүүлэн эмчлүүлсэн.

Урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулж нийт 266 эмэгтэй хамрагдаж үзлэгийн хувь 15,5% байна. Нийт 96 өвчлөл илэрсэнээс 79-г эмчлэн эрүүлжүүлж, эрүүлжилтийн хувь 82,2% байна.

**Нийгмийн, халамж, хамгаалал:** Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан хүнс тэжээлийн дэмжлэг шаардлагатай өрхийн тоон мэдээллийг гаргаж холбогдох байгууллагад явуулав. Үүнд 26 өрхийн нийт 134 гишүүн үүнээс насанд хүрэгч 63, хүүхэд 71 байлаа.

Мөн цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулж 0-18 насны хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, Бүтэн, хагас өнчин хүүхдүүдийн дэлгэрэнгүй судалгаа, хүүхдүүдийн асран хамгаалагчдын мэдээллийг баг тус бүрээр гаргаж аймгийн ГБХЗХГ-т явуулав. Судалгаанд өрх толгойлсон эцэг 13, бүтэн өнчин 7, хагас өнчин 124 хүүхэд хамрагдлаа.

**Байгаль орчин:** Сумын засаг даргын 2020 оны 03 дугаар албан даалгаврыг хэрэгжүүлэх хүрээнд "Хог хаягдал цэвэрлэх" ажлыг зохион байгуулах 39 бүлэг гарч ажилласны үр дүнд байгууллагууд 2.5 тн, айл өрхийн хашаа гудамжаас 25 тн хог ачуулж

хогийн цэгт хаялаа. 40 тн ус, 35 кг суперкилл бодисоор халдваргүйтлийн ажлыг аймгийн мал эмнэлгийн мэргэжилтний тусламжтайгаар зохион байгуулж ажиллалаа.

**Санхүү төсөв:** ХХОАТатварын хөнгөлөлт эдлэх 60 иргэний 27,892,339.99 төгрөгийг буцаан олгохоор аймгийн Татварын хэлтэст хүргүүлсэн.

2020 оны 03 дүгээр сарын орон нутгийн орлого өссөн дүнгээр **30294.6** сая төгрөг, гүйцэтгэл 149 хувь байна.

**Хөдөө аж ахуй:** Мерси корси олон улсын төслийн газраас Бэлчээрийн менежментийг сайжруулах зорилгоор бэлчээрийн ургамлын гарц тодорхойлох 4 сая төгрөгний үнэ бүхий иж бүрэн багаж тоног хэрэгслийг хүлээн авсан.

Ногоон алт төслийн газартай хамтран ажиллаж 1 худаг засваруулах ажлын төслийг хүргүүлсэн.

Сэг зэмийн устгал хийж 28 нохой 15 бод, 5 богийн сэгийг хогийн цэгийн ухсан нүхэнд хийж ариутгал хийсэн.

Өвс тэжээлийн нөөцийн үлдэгдэл 5 тн байна.

Сумын хэмжээнд 30000 толгой мал төллөсөн, том малын хорогдол 67 толгой мал үүнээс өвчнөөр 11 мал хорогдсон байна.

1,4-р багийн 13000 га талбайд бэлчээрийн хөнөөлт үлийн цагаан огтоотой тэмцэх ажил хийгдэнэ.

**Сүхбаатар аймгийн Засаг даргын Тамгын газар**